

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ШУУДАН, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ГАЗРЫН 2013 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

Мэдээллийн технологи, шуудан харилцаа холбооны газар нь Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Үндэсний хөгжлийн цогц бодлогод суурилсан Мянганы хөгжлийн зорилт, Монгол Улсын эдийн засаг нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хүрээнд салбарын бодлого, зохицуулалтын үндсэн чиглэл, зорилтуудыг ханган биелүүлэхэд чиглэсэн тус газрын 2013 оны үйл ажиллагааны төлөвлөгөө гарган ажиллалаа.

Тус газраас 2013 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийт 4 зорилтод суурилсан 175 бүтээгдэхүүн, ажил тусгасанаас дор дурьдсан төлөвлөгөөт болон Шинэчлэлийн засгийн газраас яаралтай хийж хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилтод ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Нэг. Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны салбарын хөгжил, шинэчлэлийн бодлого, дэвшилтэт технологи, сансрын технологи, өргөн нэвтрүүлэг, радио давтамжийн чиглэлээр стратегийг төлөвлөх, дэвшилтэт технологийг нутагшуулах бодлогын удирдамжаар хангах

Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны салбарын хөгжил, шинэчлэлийн бодлого, урт, дунд хугацааны стратегийг төлөвлөх, стандарт, төсөл, бодлогын удирдамжаар хангах, зөвлөгөө дэмжлэг үзүүлэх

Шинэчлэлийн Засгийн газраас хэрэгжүүлж буй иргэдэд хүнд сурталгүй, хурдан шуурхай, хүртээмжтэй төрийн үйлчилгээ хүргэх ажлын хүрээнд тус газраас “Төрийн түгжрэлгүй үйлчилгээ” зорилгын дор “Төрийн үйлчилгээний цахим машин” буюу “ТҮЦ МАШИН”-ыг Улаанбаатар хотын хүн амын суурьшилыг харгалзан 17 цэгт, аймгуудын төв, Багануур, Налайх, Замын-Үүд болон Төрийн ордонд 28 суурилуулан ашиглаж байна. Төрийн үйлчилгээний цахим машин” буюу “ТҮЦ МАШИН” нь төрийн бүхий л төрлийн үйлчилгээг хүргэх бөгөөд эхний байдлаар бүртгэлийн 6 төрлийн лавлагаа, Татварын Ерөнхий газрын 4 төрлийн лавлагаа болон аж ахуйн нэгжүүдийн үйлчилгээг хүргэнэ. Үүний дотор өдөр тутмын сонингуудын захиалга, цахилгааны төлбөрийг “ТҮЦ МАШИН”-аар дамжуулан төлөх боломжийг бүрдүүлээд байна.. Сүүлийн 6 сарын байдлаар нийт 80 мянга гаруй иргэд 90 гаруй мянган үйлчилгээ авсан байна.

ТЕГ-ын даргын 2013 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн А/54 тоот тушаалаар МТШХХГ, ХХЗХ, ТЕГ, КАБГ, МУИС-ын ХЗС болон бусад банк, үүрэн холбооны үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын хамтарсан “Мэдээллийн аюулгүй байдлын тухай” хуулийн төсөл, үзэл баримтлалыг боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. Тус ажлын хэсгээр өмнө нь бичигдэж байсан хуулийн төслүүдэд судалгаа хийн, гадны орнуудын хууль эрх зүйн зохицуулалтыг судалсаны үндсэн дээр хууль ийн төсөл, үзэл баримтлалыг боловсруулав. Хууль зүйн хэллэг, утга найруулга болон мэдээллийн аюулгүй байдлаар мэргэшсэн зөвлөхүүдээс санал авч хуулийн төсөлд тусгав. Хуулийн төсөл дээр төрийн захиргааны төв байгууллагуудаас санал авах, олон нийтийн хэлэлцүүлэг хийхээр бэлтгэн ажиллаж байна.

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 22.1.1-т заасан Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журмын төслийг боловсруулан, 2013 оны 12-р сарын 14-ний Засгийн газрын 57-р хуралдаанаар дэмжигдэн, батлагдав.

Засгийн газрын 2012 оны 5-р тогтоолын хэрэгжилтийг хангуулахаар "Төрийн албаны интернэтийн зохистой хэрэглээг бий болгох" журмын төслийг боловсруулж, төрийн захиргааны байгууллагуудаас санал авч нэгтгэн, батлуулахаар ажиллаж байна. Мөн ХХЗХ-ноос баталсан "Сайтууд дахь сэтгэгдлийн нэгдсэн харилцааг зохицуулах журам"-ын хэрэгжилтийг хангуулах ажилд хяналт тавин ажиллалаа.

Шуудангийн тухай хуулийн дагуу "Шуудангийн үндсэн сүлжээ эзэмшигчийн давуу эрхийн бүс тогтоох" тухай шийдвэрийн төслийг боловсруулан, Ерөнхий сайдын 2013 оны 24 тоот захирамжаар батлуулав.

Цахим гарын үсгийн хэрэглээ, нийтийн түлхүүрийн дэд бүтэцтэй холбоотой багц журам, бодлого зохицуулалтын орчныг боловсронгуй болгох ажлын хүрээнд нийтийн түлхүүрийн дэд бүтцийн багц 5 стандарттай танилцан санал өгч ХХЗХ руу хүргүүлэв.

Өгөгдөл хамгаалах тухай хуулийн үзэл баримтлалыг батлуулж, хуулийн төслийг ЗГХЭГ-т хүргүүлж, ҮАБЗ-д танилцуулах ажлын хүрээнд КАБГ дээр байгуулагдсан ажлын хэсэгтэй хамтран ажиллав.

Гүүгл орчуулгын системд Монгол хэл нэмэх ажлын хүрээнд төрийн бүх байгууллагуудад монгол-англи хадмал орчуулга цуглуулах ажилд дэмжлэг үзүүлэх хүсэлт бүхий албан тоотыг хүргүүлэн нийт 600 000 үг цуглуулж Сан Франциско дахь Консулын газраар дамжуулан Гүүгл-д хүргүүлэв.

Төрийн түгжрэлгүй үйлчилгээ" зорилтын хүрээнд төрөөс иргэд, аж ахуй нэгжид үзүүлдэг үйлчилгээний жагсаалтыг Засгийн газрын 28 агентлаг болон Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас гаргуулан авч, давхардсан байдлаар нийт 1434 төрлийн төрийн үйлчилгээг бүртгэн авлаа.

"Шуудангаар үйлчлэгч болон шуудан тээвэрлэгч байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах журам"-ын төслийг шинэчлэн боловсруулж, ЗГХЭГ-т хүргүүлсэний дагуу холбогдох шийдвэрийг гаргуулсан болно.

Улсын төсвийн 2014 оны хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр төлөвлөж буй Шуудангийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгоор тусгай зориулалтын автомашин нийлүүлэх, Шуудангийн ухаалаг хайрцаг нийлүүлэх, суурилуулах /21 аймаг/, Шуудангийн ялган боловсруулах төвийн барилга барих, тусгай зориулалтын тоног төхөөрөмж нийлүүлэх, суурилуулах төслүүдийг тус тус боловсруулан, танилцуулгыг Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлэв.

Нийслэлийн хот төлөвлөлтийн болон орон нутгийн засаг захиргааны нэгжийн өөрчлөлтөд тулгуурлан шинэчлэн боловсруулсан Бүсчлэлийн нэгдсэн кодын шинэчилсэн жагсаалттай холбогдох саналыг Харилцаа холбооны зохицуулах хороонд хүргүүлэв.

Нийтийн түлхүүрийн дэд бүтэц байгуулах төслийн бодлогын даалгаврыг боловсруулан уг төслийг хэрэгжүүлж эхлэв.

Улаанбаатарт паспорт хяналтын нэгдсэн сүлжээ төслийг үргэлжлүүлэх ажлын хүрээнд Консулын үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх төслийн судалгааг хийж, бодлогын даалгаврыг боловсруулан, системийн анализ дизайныг хийв.

Үндэсний дата төв дээр төрийн байгууллагуудын өгөгдлийн сан байршуулж эхэлсэн бөгөөд шинээр цахимжиж байгаа үйлчилгээ, өгөгдлийн санг УБЕГ, ТЕГ зэрэг газруудын өгөгдлийн сантай холбогдох асуудалд санал тусгуулав.

Засгийн газрын 2013 оны 3-р сарын 2-ны өдрийн 69-р тоот тогтоолоор Гадаад худалдааг хөнгөвчлөх ЦНЦ-ыг хэрэгжүүлэх удирдах хороог шинэчлэн байгуулсан. Удирдах хороог мэдээлэл, мэргэжил арга зүйгээр хангах үүрэг бүхий Бизнес процессийн, Эрх зүйн, Технологийн, Сургалт хамтын ажиллагааны зэрэг дэд хороодыг байгуулан ажиллаж байна. Удирдах хороог ЗГХЭГ удирдан зохион байгуулан ажиллаж байна.

Ерөнхий сайдын 2013 оны 9-р сарын 20-ны өдрийн 139 дүгээр захирамжаар Эрүүл мэндийн салбарт улсын төсөв, гадаадын зээл, тусламжаар хэрэгжсэн болон одоо хэрэгжүүлж байгаа програм хангамж, дэд бүтцэд судалгаа хийж, цаашид авах арга хэмжээний талаар санал дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Тус ажлын хэсгээр 1,2,3 дахь шатлалын нийт 9 эмнэлгээр явж, эмнэлгүүдийн мэдээллийн технологийн өнөөгийн байдал, хүний нөөц, програм хангамж, мэдээллийн систем, сүлжээ дэд бүтэц, хөрөнгө оруулалт, МТ-ийн бичиг баримттай танилцан судалгаа хийн тайлан гаргав. Эмнэлэгүүдийн өнөөгийн байдалтай танилцсан талаар тайлан гаргаж, ажлын хэсгийн гишүүдийн санал дүгнэлтүүдийг нэгтгэн боловсруулж Ерөнхий сайдад танилцуулсан. Эрүүл мэндийн салбарт 2007 оноос хойш хэрэгжсэн төсөл, хөтөлбөрүүдийн дэлгэрэнгүй судалгааг гарган, цаашид эрүүл мэндийн мэдээллийн системийг боловсронгуй болгон хөгжүүлэх, эрүүл мэндийн салбарын онцлогийг тусгасан, өөр хоорондоо холбогдож харилцан мэдээлэл солилцдог нэгдсэн систем бүхий эрүүл мэндийн энтерпрайз архитектурыг бий болгохоор төлөвлөөд байна.

Монгол улсын телевизийн стандартыг шинэчлэх, олон улсын түвшинд хүргэх, хууль эрх зүйн бодлогын баримтлах чиглэлийг боловсронгуй болгох чиглэлээр ажлын хэсгийн 4 удаагийн хуралд оролцож, АВU –ээс ирсэн мэргэжилтнүүдтэй уулзалт хийж хууль эрхзүйн хувьд шинэчлэл хийх талаар 2-3 хувилбар бүхий саналыг боловсрууллаа.

Мэдээлэл, холбооны өндөр технологийн судалгаа-хөгжил, инновацийг дэмжих ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд програм хангамжийг хөгжүүлэхэд тулгамдаад буй асуудлын хүрээнд 7 дэд хэсэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажилласан. Үүнд програм хангамжийн тендерийг тоног төхөөрөмжийн тендерээс тусад нь зарлах, жишиг баримт бичигт өөрчлөлт оруулах, татвараас чөлөөлөх, кластерийн чиглэлээр, оюуны өмчийг барьцаалан зээл авах талаар, компаний үнэ цэнийг тогтоох зэрэг чиглэлээр ажиллаж үр дүнд нь “Монголын програм хангамжийн үйлдвэрлэлийн салбарын анхдугаар чуулган”-ыг зохион байгуулахаар шийдвэрлэв.

Чип дизайны үйлдвэр байгуулах суурь судалгаа хийж, төсөл боловсруулав.

Иргэний биометрик мэдээлэл тулгуурласан олон улсын ICAO стандартад нийцүүлэн гаргах цахим гадаад паспортыг нэвтрүүлэх ТЭЗҮ-ийг боловсруулан ЭЗХЯ болон Сангийн Яаманд санхүүжилт хүсэн хүргүүлсэн.

Хэвлэлийн хүргэлтийн тээврийн зардлын алдагдлыг багасгах зорилгоор 21 аймагт хэвлэх машиныг суурилуулан тэнд нь хэвлэдэг санааг дэвшүүлэх холбогдох судалгааг хийж төслийг боловсруулан удирдлагад танилцуулсан.

Засгийн газрын 2012 оны 5-р тогтоолын хэрэгжилтийг хангуулахаар "Төрийн албаны интернэтийн зохистой хэрэглээг бий болгох" журмын төслийг боловсруулж, төрийн захиргааны байгууллагуудаас санал авч нэгтгэн, батлуулахаар ажиллаж байна. Мөн ХХЗХ-ноос баталсан "Сайтууд дахь сэтгэгдлийн нэгдсэн харилцааг зохицуулах журам"-ын хэрэгжилтийг хангуулах ажилд хяналт тавин ажиллалаа.

Хөдөлмөрийн Яамны "Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр" боловсруулах ажлын хэсэгт ажиллан, уг хөтөлбөрт МТХХ-ны салбарыг тэргүүлэх салбараар тодорхойлох, бизнесийн дундын зөвөлгөө өгдөг зөвлөх үйлчилгээ ажиллуулах саналыг тусгав. Мөн салбарын чиглэлээр гарааны бизнес эрхлэх сонирхолтой иргэн, аж ахуйн нэгжид жижиг дунд үйлдвэрийн зээл олгох хамтын ажиллагааны санамж бичиг зурж, одоогоор компаниудын материалыг хүлээн авч байна.

Шинэ зууны боловсрол төслийн хүрээнд мэдээллийн сүлжээг аймгийн төв хүргэхээр гаргасан сүлжээний зурагтай танилцан, энэхүү зураглалыг МХС компаний үндсэн сүлжээ болон, энэ жил интернэт үйлчилгээ хүргэх 60 сумын төсөлтэй уялдуулж, давхацлыг арилгаж, давхардлын оронд хичээлийн дотуур байранд хүргэх шийдлийг гаргаж МТ-ийн зөвлөлд танилцуулан дэмжигдсэн.

Мэдээллийн технологи, харилцаа холбооны салбарт мөрдөгдөж байгаа хууль, стандарт, дүрэм журмын нэр томъёоны тодорхойлолтонд орсон салбарт ашиглагддаг, өөрөөр тодорхойлогдсон болон буруу томъёолсон үгсийн судалгааг хийв. Салбарын онцлогоос шалтгаалан ижил утгатай ч Англи, Монголоор хольж бичдэг үг, тодорхойлолтын судалгааг хийлээ.

Монгол Улсын Мэдээлэл, харилцаа холбооны талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн төслийг шинэчлэлийн засгийн газрын хөтөлбөр, салбарын стратегийн зорилтуудтай уялдуулан тодотгосны үндсэн дээр ХХЗХ, салбарын байгууллагуудын саналын авч тусган, газрын даргын хуралд танилцуулав.

УИХ-аас 2013 оны 02 дугаар сарын 07-ны өдөр баталсан Хаягжуулалтын тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Газрын харилцаа, геодези, зураг зүйн газраас боловсруулж буй "Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам"-ын төсөлтэй танилцан холбогдох саналыг хүргүүлэв.

Цахим засаг, бүртгэл мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох, дэвшилтэт болон сансрын технологийг нутагшуулах, газар сансар хосолсон өргөн зурвасын сүлжээг бий болгох, тандан судалгааны мэдээг үндэсний хэмжээнд ашиглах, хэрэглээг нэвтрүүлэх

Засгийн газрын 2012 оны 137-р тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Үндэсний хиймэл дагуул хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхэд шаардлагатай олон улсын хамтын ажиллагаа, хөтөлбөрийн санхүүжилтийн талаар 2013 оны 1 дүгээр сарын 19 өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулга хийж, 5 дугаар тэмдэглэл гаргуулав. Япон улсын Эдийн засаг, худалдаа, үйлдвэрлэлийн яамнаас Үндэсний хиймэл дагуул хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах хүсэлтээ илэрхийлсний дагуу ЭЗХҮЯ болон Япон улсын сансрын технологийн үйлдвэрлэл эрхлэгч хувийн хэвшлийн байгууллагуудын төлөөлөгчид 2013 оны 3 дугаар сарын 14-ний өдөр тус газарт хүрэлцэн ирж уулзалт хийсэн. Мөн Японы талын төлөөлөгчид болон Сансрын үндэсний зөвлөлийн гишүүдтэй хамтарсан уулзалтыг зохион байгуулж тус саналыг хэлэлцэж Ерөнхий сайдад танилцуулсан .

“Монгол Улсын Үндэсний хиймэл дагуул хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллах “Сансрын үндэсний зөвлөл”-ийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2013 оны 16 дугаар захирамжаар байгуулав. Сансрын үндэсний зөвлөлийг Ерөнхий сайдын дэргэд 4 удаа, ажлын алба буюу МТШХХГазарт 15 удаа уулзалт, хуралдаан хийлээ. Сансрын холбооны болон тандан судалгааны хиймэл дагуул хөөргөх чиглэлээр хамтран ажиллахаар ирүүлсэн улс орнууд, гадаадын компаниудын төлөөлөгчидтэй уулзалт зохион байгуулж, тэдгээрийн саналуудад техникийн дүгнэлт гаргах хэлбэрээр зөвлөмж боловсруулан Засгийн газрын хуралдаанд танилцуулсан.

Засгийн Газрын 137 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Үндэсний хиймэл дагуул” хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын хүрээнд тандан судалгааны хиймэл дагуул үйлдвэрлэгч, хөөргөгч БНХАУ-ын Хятадын сансрын технологийн академи, Япон улсын Эдийн засаг, аж үйлдвэр, худалдааны яам, Англи болон Япон улсуудын компаниуд болох Эс Эс Ти Эл болон ЖАМСС, Франц улсын Астриум, Итали-Франц улсын хамтарсан Талес алейна спейс зэрэг компаниудтай уулзалт зохион байгуулсан. Монгол Улсын хэрэгцээ шаардлагад нийцсэн хиймэл дагуулын талаар Сансрын үндэсний зөвлөлийн хүрээнд хэлэлцүүлж, зохих зөвлөмж гаргуулахаар Монгол Улсын Засгийн газар болон Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулга бэлтгэн хүргүүлэв.

“Үндэсний хиймэл дагуул хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд сансрын холбооны болон тандан судалгааны хиймэл дагуулын сүлжээ байгуулах талаарх зөвлөх үйлчилгээний тендерт шалгарсан Франц улсын Сатконсалт компанитай ХААГ-3-2013/ XII-05-02,01 тоот гэрээг МТШХХГ болон Худалдан авах ажиллагааны газартай хамтран байгуулж гэрээт ажлыг эхлүүлсэн. Энэхүү гэрээнүүдийн дагуу төслийн зөвлөхүүдтэй 2013 оны 8 дугаар сарын 6-аас 9- ны өдрүүдэд тус бүр хоёр удаа ажлын даалгавар болон гэрээнд тусгагдсан ажлын явц гүйцэтгэлийн талаар уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж, гадна гэрээний үүргийн дагуу хийгдэж байгаа ажлуудын гүйцэтгэлд хяналт тавиж ажиллаж байна. Уг гүйцэтгэлийн дагуу холбооны хиймэл дагуул үйлдвэрлэгчийн дэлгэрэнгүй саналд хэрэглэгдэх RFI (Request for Information) боловсруулж Астриум, Талес Алейна Спейс, Бойнг, Эй Би Эс компаниуд руу санал авахаар хүргүүлээд байна.

Олон улсын цахилгаан холбооны байгууллагад шинэ хиймэл дагуул хөөргөх Sansar-3 API хүсэлтийг боловсруулах ажлыг хийж дуусган, ОУЦХБ-ын холбогдох товчоонд хүргүүлэв.

Олон улсын цахилгаан холбооны байгууллагад явуулсан Sansar-2 хүсэлтийн дагуу CR/C буюу бусад хиймэл дагуулын сүлжээ төлөвлөлттэй радио давтамжийн харилцан нөлөөлөл үүссэн тохиолдолд зөвшилцөл хийх хүсэлтийг боловсруулах ажлыг зөвлөх үйлчилгээ үзүүлэгч Сатконсалт компаний зөвлөхүүдтэй хамтран боловсруулж ОУЦХБ-ын холбогдох товчоонд хүргүүлсэн.

Зөвлөх үйлчилгээ үзүүлэгч Satconsult компани болон туслан гүйцэтгэгч Геомеп ХХК-тай хамтарч Хиймэл дагуулын газрын станц байгуулах оновчтой байршил сонгох ажлын хүрээнд холбогдох хүмүүсийн уулзалт болон Улаанбаатар орчимд байрлах сайтын давтамжийн нөлөөллийн хэмжилтийг эхний байдлаар сонгогдоод байгаа 4 газарт хийлээ. Дээрх сонгогдсон газруудын газрын кадастрын зураглалыг гаргаж харъяа орон нутгийн засаг захиргааны байгууллагуудад газар эзэмших хүсэлтээ илгээгээд байна.

Сансрын долгионы давтамж зохицуулалтын бүлэг олон улсын байгууллагатай хамтран ажиллах, цаашид гишүүнчлэлээр элсэх асуудлыг судлаж дууссан. Тус байгууллагын зохицуулагч Edoardo Marelli (Head of the ESA Frequency Management Office) –тай холбогдож зөвлөмж авсаны дагуу Монгол Улсын Гадаад Харилцааны Яаманд хандан тус байгууллагад элсэх боломжийн талаар албан бичгээр санал явуулсан. ГХЯ-наас 2013 оны 02 дугаар сарын 06 өдрийн 09/720 тоот албан бичгээр дэмжсэн санал авсаны дагуу Сансрын долгионы давтамж зохицуулалтын бүлэгт элсэх боломжтой талаар холбогдох материалыг хүргүүлээд байна. Ингэснээр тус байгууллагын 34 дэхь ээлжит уулзалтыг АНУ-ийн Үндэсний далай, агаар мандалын алба 2014 оны 6 дугаар сарын 3-11 хооронд АНУ-д зохион байгуулах бөгөөд энэ үеэр тус байгууллагад гишүүнээр элсэх хүсэлтээ гаргах боломжтой болсон

Олон улсын хиймэл дагуулын мастер бүртгэлд бүртгүүлэхтэй холбоотой Сансар-1, 2, 3 хиймэл дагуулын сүлжээний төлөвлөлтийн эх загварыг (roadmap) боловсруулаад байна.

Олон улсын цахилгаан холбооны байгууллагын Ази Номхон Далайн орны салбарын 2014 онд тусгах ажлын төлөвлөгөөнд хиймэл дагуул, дөрөвдүгээр үеийн хөдөлгөөнт холбоо, тоон радио телевизийн шилжилтийн талаар төслийн санал боловсруулж танилцуулсан.

Олон улсын цахилгаан холбооны байгууллагын Ази Номхон Далайн орны салбарын 2014 онд тусгах ажлын төлөвлөгөөнд хиймэл дагуул, дөрөвдүгээр үеийн хөдөлгөөнт холбоо, тоон радио телевизийн шилжилтийн талаар төслийн санал боловсруулж танилцуулсан.

Satconsult компаниас зохион байгуулсан сургалтанд заагдсан материалуудыг нэг бүрчлэн танилцаж гео орбитод байрлах холбооны хиймэл дагуулын ашиглагдах радио давтамжийг ОУЦХБ-д бүртгүүлэхтэй холбоотой олон улсын радио давтамжийг түүвэрлэн авч судалгааг хийсэн.

Тус газрын даргын тушаалаар Төрийн байгууллагуудын мэдээллийн санг “Үндэсний Дата төв” УТҮГ-т шилжүүлэн төвлөрүүлэх ажлын хэсгийг байгуулсан. Уг ажлын хэсгийн хүрээнд Тагнуулын ерөнхий газар болон Кибер аюулгүй байдлын газартай хамтран Төрийн мэдээллийн санг ҮДТ-д шилжүүлэн төвлөрүүлэх журмыг боловсруулан ТЕГ болон МТШХХГ-ын дарга нараар батлуулан мөрдлөг болгон ажиллаж байна.

“Цахим засаглалын мэдээллийн сан, мэдээллийн системийг хөгжүүлэх” төслийн багц тус бүрийн гүйцэтгэлийн тайланг авч 2012 оны үлдэгдэл санхүүжилт нээлгэхтэй холбоотой албан тоотыг Сангийн яаманд хүргүүлээд байна. Мөн төсөлтэй холбоотой тоног төхөөрөмжийг ҮДТ-д байршуулан холбогдох мэдээллийн системийг ажиллуулаад байна.

Монгол Улсын 2013 оны төсөвт тусгагдсан “Улсын мэдээллийн нэгдсэн өгөгдлийн санг үүсгэх”, “Улсын газарзүйн мэдээллийн санг үүсгэж, програм хангамжийн дэд бүтцийн давхарга бэлдэх”, “Мэдээллийн синхрон ажиллагаатай нөөцийн бүтэц үүсгэх” зэрэг төслүүдийг хэрэгжүүлэв.

Үндэсний радио давтамжийн нөөцийг үр ашигтай, зүй зохистой ашиглах, шударга, тэгш хуваарилах талаар бодлого боловсруулж, хэрэгжилтийг хангуулах

Монгол Улсад радио, телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэх шилжилтийн үеийн баримтлах чиглэлд нэмэлт өөрчлөлт оруулан боловсруулж, тус Газар болон Харилцаа холбооны зохицуулах хорооноос санал авч, 12 дугаар сарын 17-ны өдөр ДЗХ-аар хэлэлцүүлэв.

Улаанбаатар хот болон хот орчмын нэг давтамжит сүлжээ төлөвлөлтийг боловсронгуй болгох зорилгоор нэг давтамжийн сүлжээнд ажиллах тоног төхөөрөмжийн судалгаа, тэдгээрийн техникийн шаардлагуудыг боловсруулан, ХХЗХ, НМТГ, РТС УТҮГ, ДДэш ТВ ХХК, МХТС зэрэг байгууллагуудын холбогдох төлөөллүүдийг хамарсан хэлэлцүүлэг хийсэн. Тус хэлэлцүүлгээр гарсан саналуудыг тусган, Баянхошуу, Дарь эх, Богд Уул зэрэг газруудад дэд бүтцийг шинээр байгуулан, хуучин сайтуудад тоног төхөөрөмж суурилуулахаар болов.

Монгол улсын радио давтамжийн спектр ашиглалтын байдал Олон улсын хөгжлийн чиг хандлагын талаар судалгаа хийх талаар илтгэлийг боловсруулан газар, хэлтсийн удирдлагуудад танилцуулсан.

Дэлхийн Радио Холбооны Дүрэмд орох өөрчлөлтийн талаар APG-2 хурлын үр дүнд үндэслэн хиймэл дагуултай холбоотой хэлэлцэх асуудлын талаар явцын судалгаа хийж байна.

Холбооны хиймэл дагуул хөөргөх талаар Олон улсын цахилгаан холбооны байгууллагатай хийгдэх зохицуулалтын явцын талаар Ерөнхий сайдад танилцуулах илтгэл бэлтгэсэн.

Телевиз, радиогийн өргөн нэвтрүүлгийн талаарх бодлого боловсруулах, өргөн нэвтрүүлгийг аналог системээс тоон технологид шилжүүлэх ажлыг зохион байгуулах

Монгол Улсад телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэх бодлого, зохицуулалтын шийдлүүдийг эцэслэн боловсруулах ажлын хүрээнд тус газар болон ХХЗХ-ны хамтарсан ажлын хэсэг байгуулагдан тоон телевизийн сүлжээний шийдэл, хөрөнгө оруулалтын тооцоо болон бусад бодлого зохицуулалтын шийдлийг боловсруулан тус Газрын даргын зөвлөлийн хурлаар оруулан шинэ DVB-T2 станц байгуулах сүлжээний шийдлийн сонголтыг хийгээд байна.

“Монгол Улсад тоон телевизийн өргөн нэвтрүүлгийг хүлээн авах хэрэглэгчийн төхөөрөмжийг нийлүүлэх, түгээх бодлогын чиглэл” -ийг боловсруулан, хэрэглэгчийн хүлээн авах төхөөрөмжийг зах зээлд нийлүүлэх, түгээх журамд нэмэлт өөрчлөлт оруулан боловсруулж

харьяа салбар байгууллагууд болон телевизор импортлогч, үйлдвэрлэгч, гаалийн ерөнхий газар, мэргэжлийн хяналтын газар зэрэг нийт 21 байгууллагаас санал аван, уг журмын төсөл, холбогдох материалуудын хамт ХХЗХ-д хүргүүлсэн.

Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын 2013 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 100 тоот тушаалаар “Монгол Улсын радио, телевизийн өргөн нэвтрүүлгийг аналог системээс тоон системд шилжүүлэх” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор тоон радиогийн зохицуулалтын чиглэл, техникийн шийдэл боловсруулах ажлын хэсэг байгуулагдан “Тоон радиогийн зохицуулалтын чиглэл, техникийн шийдэл боловсруулах ажлын хэсгийн тайлан” боловсруулсан ба тус ажлын хэсгийн хүрээнд Радио өргөн нэвтрүүлгийн стандарт сонголт, техникийн шийдэл боловсруулах, Зурвасын хуваарилалт хийж, хамрах хүрээг тодорхойлох, Радио өргөн нэвтрүүлгийн эрхзүй зохицуулалтын санал боловсруулах, үнийн судалгаа хийх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Радио давтамжийн төлөвлөлт, ашиглалтын журам, Радио давтамжийн ашиглалтын нэгдсэн бүртгэл хөтлөх журмын хэрэгжилтийг хангуулах, байнгын ажлын хэсгийн МТШХХГ-ын даргын 2012 оны 44 дүгээр тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийг 4 удаа зохион байгуулсан бөгөөд шаардлагатай WRC 15-н хөтөлбөр дээр ажиллаж байна. Мөн Радио давтамжийн төлөвлөлт, ашиглалтын журмын дагуу Үндэсний радио давтамжийн зурвасын төлөвлөлтийг МТШХХГ-ын 2013 оны 37 дугаар тоот тушаалаар батлуулсан.

Хил орчмын радио давтамжийн зохицуулалт хийх зорилгоор ОХУ-тай хамтран 2013 оны 4 дүгээр сарын 15-наас 19-ний өдрүүдэд ОХУ-ын Москва хотод Харилцаа холбоо болон олон нийтийн хэвлэл мэдээллийн яамны харъяа “Радио давтамжийн ерөнхий газар”-тай хамтран телевиз, радиогийн өргөн нэвтрүүлгийн, үүрэг холбооны үйлчилгээний радио давтамжийн зохицуулалтын нийт 6-н хэлэлцээрийн төслүүдийг боловсруулсан. Дээрхи 6 гэрээний төслийг Засгийн газрын 2013 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн, гэрээнд 2013 оны 9 дүгээр сарын 19-ны өдөр 2 тал гарын үсэг зурав.

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 275 тоот тогтоолоор батлагдсан “Радио, телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тус газраас “Монгол Улсын телевизийн өргөн нэвтрүүлгийг аналог системээс тоон систем рүү шилжүүлэхэд шаардагдах тоног төхөөрөмж нийлүүлэх, суурилуулах” (ТН-01/11) төслийг улсын төсвийн санхүүжилтээр 2011 оноос эхлэн хэрэгжүүлж байна. Энэхүү төслийн хүрээнд тоон телевизийн дахин дамжуулах станцын тоног төхөөрөмжүүдийг 10 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 2014 оныг дуустал нийт 200 сум, суурин газар суурилуулах бөгөөд 2,1 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 2011, 2012 онд Говьсүмбэр аймгийн 3 сум, Дорноговь аймгийн 15 сум, Дундговь аймгийн 15 сум, Өмнөговь аймгийн 14 сум нийт 47 сумдад телевизийн дахин дамжуулах станцын төхөөрөмжүүдийг суурилуулсан.

МТШХХГ-ын даргын 2012 оны 45 дугаар тоот тушаалаар тус төслийн хүрээнд суурилагдсан тоног төхөөрөмжийг хүлээн авах, байнгын ашиглалтад оруулах комисс байгуулагдан 2012 оны 12 дугаар сард, 2013 оны 5 дугаар сард 2 чиглэл гарган ажилласан. Тус комисс нь сум бүрт хэмжилт шалгалт хийж, акт үйлдэн, холбогдох материалуудыг боловсруулан ашиглалт үйлчилгээ хариуцах Радио телевизийн сүлжээ УТҮГ-т Төрийн өмчийн хорооны 2013 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 401 тоот тогтоолоор нийт 47 сайтын тоног төхөөрөмжийг

хүлээлгэн өгч байнгын ашиглалтанд оруулахад бэлэн болоод байна. Мөн тус төслийн хүрээнд 1,6 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 2013 онд: Төв аймгийн 13 сум, Сүхбаатар аймгийн 7 сум, Булган аймгийн 3 сум, Хэнтий аймгийн 3 сум, Дорнод аймгийн 5 сум, Архангай аймгийн 3 сум, Өвөрхангай аймгийн 4 сум нийт 38 сумдад тоон телевизийн дахин дамжуулах станцын төхөөрөмжүүдийг суурилуулсан.

Нийслэлийн худалдан авах ажиллагааны газраас зарласан “Хотын аналог, өргөн нэвтрүүлгийн телевизийн станцуудыг тоон технологид шилжүүлэх” НХААГ-13/0403 тендертэй холбогдуулан сүлжээ төлөвлөлтийн тоног төхөөрөмжийн техникийн шаардлагыг боловсруулан, нийслэлийн худалдан авах газарт хүргүүлсэн.

Харилцаа холбооны зохицуулах хороо болон Радио телевизийн сүлжээ УТҮГ-т 2014 онд тоон телевизийн дахин дамжуулах станц суурилуулах сайтуудын санал авахаар хүргүүлээд байна.

Төв аймгийн Баянчандмань суманд тоон телевизийн хуучин нэвтрүүлэгчийг ашиглах боломжийн талаарх, ДДЭШ ТВ ХХК-ийн газрын станц дээр R&S тоног төхөөрөмжийг техникийн нөхцөл шаардлага хангаж байгаа эсэх, хамрах хүрээ, ХБНГУ-ын Rohde & Schwarz компанийн тоон телевизийн дахин дамжуулах станцын тоног төхөөрөмжийг Төв аймгийн Зуунмод суманд, Баянчандмань, Жаргалант суманд филтерийн судалгаа, туршилт хийлээ.

“Монгол Улсын телевизийн өргөн нэвтрүүлгийг аналог системээс тоон системд шилжүүлэхэд шаардагдах тоног төхөөрөмж нийлүүлэх суурилуулах” ТН01/11 төслийн 2014 оны захиалгыг хийлгүүлээ.

Тоон телевизийн дахин дамжуулах станц суурилуулахтай холбоотой 2014 онд зарлах тендерийн бичиг баримт боловсруулж байна

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдааны 67 дугаар тэмдэглэлийн XII/3-д заасны дагуу тус ажлыг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, 3.1.1-д заасны дагуу төсвийн болон гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр 2013 онд хэрэгжүүлэх мэдээллийн технологийн төсөл, хөтөлбөрүүдийн дэлгэрэнгүй танилцуулгыг авахаар төрийн захиргааны 79-н байгууллагад албан тоот хүргүүлсэн. Үүнээс нийт 53-н байгууллага төслийн танилцуулгаа ирүүлсэн бөгөөд тус материалаа хангалттай ирүүлсэн 18, хангалтгүй 13, дэмжлэг хүссэн 2, төсөл хөтөлбөр байхгүй 18, санхүүжилт нь шийдэгдээгүй 2 төсөл ирсэн болно. Төслийн материалаа ирүүлээгүй 26 байгууллага бүртгэгдсэн. Тус тэмдэглэлийн 3.1.1-т заасны дагуу төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн чиглэлээр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн уялдаа, холбоог хангах, хөрөнгө оруулалтын давхардлыг арилгах үүднээс 2013 оны 06-р сарын 28-ны өдөр Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яам зэрэг нийт 15 газарт 2014 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусган ажиллах боломжтой төслийн жагсаалтыг хүргүүлсэн.

Олон улсын Шуудангийн илгээмжийн гаалийн бүрдүүлэлтэй холбоотой асуудлаар Гаалийн ерөнхий газар, ХХЗХ зэрэг холбогдох байгууллагуудтай 4 удаагийн уулзалт зохион байгуулж, Монгол Улсын сайд бөгөөд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга болон Сангийн сайдын хамтран баталсан 2010 оны 30/20 тоот журамд нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулан

Гаалийн ерөнхий газарт хүргүүлсний үр дүнд олон улсын гарах шуудангийн илгээмжид тавигддаг зарим хязгаарлалтын цуцлах тухай ГЕГ-аас мэдэгдсэн болно.

Засгийн газрын 2011 оны 145 тоот тогтоолоор батлагдсан “Өндөр хурдны өргөн зурвасын сүлжээ” хөтөлбөр, 126-р тогтоолоор батлагдсан “Өрх бүрт шуудан” хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг тус тус гаргаж холбогдох газруудад хүргүүлсэн.

Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2009 оны 153 тоот тогтоолоор батлагдсан “Нийслэлийн гудамж, замын хөдөлгөөнд ачааны автомашиныг зохицуулалттайгаар оролцуулах түр зөвшөөрөл олгох журам”-д нэмэлт өөрчлөлт оруулахтай холбогдуулан “Шуудангийн зориулалт бүхий ачааны автомашиныг хотын төвийн доторхи замаар төв замын зөвшөөрөлгүй зорчуулах” талаар холбогдох саналыг албан тоотоор хүргүүлж, тусгуулсан.

Шуудангийн маркийн сэдвийн хэвлүүлэх төлөвлөгөөг боловсруулж, ерөнхий сайдын захирамжаар батлуулав.

Монгол Улс, БНХАУ-ын шуудангийн салбарт хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичиг, шуудангийн оператор хоорондын үйл ажиллагааны талаарх хэлэлцээрийн төслийг боловсруулснаар хоёр улсын гадаад харилцаа хамтын ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдав.

Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2013 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 31 дүгээр тушаалаар “Тусгай хэрэглээний сүлжээ байгуулах, ашиглахтай холбоотой журам боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг” байгуулан ажиллав. Тус ажлын хэсэг нийт 9 удаа ажлын хэсгийг хуралдаж, уг журмын төслийг боловсруулсан ба журмын төслийг Тагнуулын ерөнхий газраас 2013 оны 3 дугаар сарын 29-ний өдөр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.

Контентийн бодлого, зохицуулалтын баримтлах чиглэл боловсруулах ажлын хүрээнд төслийн танилцуулга бэлтгэн ЭЗХЯ-нд хүргүүлээ.

Мэдээллийн технологийн зөвлөлийг Ерөнхий Сайдын дэргэд 2012 оны 10 дугаар сарын 22 нд байгуулж, салбарын тулгамдаж буй асуудлын чиглэлээр 7 хоног бүр хуралдан хэлэлцэж үйл ажиллагааг тогтмолжуулсан. Мэдээллийн технологийн зөвлөл нь анх 35 гишүүнтэй байгуулагдаж байсан бол одоогоор 53 гишүүнтэй болсон бөгөөд өнгөрсөн жил нийт 51 удаа хуралдаж, 36 асуудал хэлэлцсэн байна.

ЭЗХЯ-д бодлогын судалгааны чиглэлээр 5 судалгааны ажлын танилцуулгыг боловсруулан хүргүүлээ. Үүнд: МТ-ийн аудитын тогтолцоог нэвтрүүлэх, Монгол контентийг хөгжүүлэх гадаадын болон дотоодын хөгжүүлэлтийн бодлого, Тоон хуваагдлыг багасгах бодлогын судалгаа, Хууль эрхзүйн шинэчлэлтийн судалгаа, Төрөөс баримтлах бодлогын судалгаа зэрэг болно.

Шуудангийн салбарт тулгамдаад байгаа асуудал болон цаашид хийх шаардлагатай зорилт, үйл ажиллагааны талаар холбогдох мэдээллийг бэлтгэн Ерөнхий сайдад танилцуулсаны үр дүнд “Шуудангийн хот хоорондын тээвэр логистикийн үйлчилгээний зориулалтын автомашин худалдан, мэдээллийн технололги нэвтрүүлэх, “Ухаалаг шуудангийн хайрцаг” суурилуулах зэрэг 5 багц бүхий төслийг амжилттай хэрэгжүүлэв.

“Шуудангийн салбарын хөгжлийн ирээдүй, зохицуулалт-2014” сэдэвт форумыг ХХЗХ-той хамтран зохион байгуулав.

Монгол Улсын Засгийн газрын 2013-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулахад шуудангийн чиглэлээр санал боловсруулан тусгасан.

Хууль зүйн яам дээр байгуулагдсан Архивын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллан, МХХТ-ийн талаар анхаарч талаар холбогдох зөвлөмж, хуулийн үзэл баримтлал болон саналаа боловсруулж хүргүүлсэн.

Мэдээлэл холбооны сүлжээ ТӨК-иас боловсруулсан “Холбооны кабелийн суурилуулалт”, “Телефоны хуваарилах шүүгээ, 100 хосын төгсгөлийн блок суурилуулалт” зэрэг стандартуудын төсөлтэй танилцан саналаа хүргүүлэв..

МТШХХГ болон Нийслэлийн Засаг даргын тамгын газар хоорондын хамтын ажиллагаагаа сайжруулах үүднээс Хамтын ажиллагааны санамж бичгийн төслийг боловсруулав.

Засгийн газрын 2007 оны 200 тоот тогтоолоор батлагдсан “Бүсчлэлийн кодыг нэвтрүүлэх, хэрэглэх журам”-ын дагуу Бүсчлэлийн кодыг дахин хянаж, өөрчлөлт оруулан хэвлэлийн эхийг ХХЗХ-той хамтран бэлтгэж, бүсчлэлийн кодын гарын авлагыг хэвлүүлсэн.

Шуудангийн илгээмжийг ялган боловсруулах төв терминалын барилга, Улаанбаатар хотын томоохон худалдааны төв, авто тээврийн вокзалыг түшиглэн шуудангийн логистикийн агуулах барих газрын зөвшөөрөл авах талаар танилцуулгыг холбогдох материалуудын хамт хотын захирагчид хүргүүлэв.

МТШХХГ болон Зэвсэгт хүчний жанжин штаб хоорондын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор Хамтын ажиллагааны санамж бичгийн төслийг боловсруулсан.

Мэдээлэл холбооны сүлжээ ТӨК-ийн эзэмшилд байгаа физик кабелийг Монголын цахилгаан холбоо ХК-д шилжүүлэхтэй холбоотой нарийвчилсан тооцоо судалгааг хийж, уг ажлын хэсгийн тайланг бэлтгэн Ерөнхий сайдын 2013 оны 39 тоот захирамжаар байгуулагдсан МЦХ ХК-ийн асуудлаар БНСУ-ын Корей Телеком корпорацитай хэлэлцээ хийх үүрэг бүхий ажлын хэсэгт танилцуулсан.

Харилцаа холбооны зохицуулах хороо болон Швейцарын “Macmillian Keck Attorneys and Solicitors” компаниас 2013 оны 3-р сарын 26-ны өдөр зохион байгуулсан “Тусгай зөвшөөрлийн тогтолцоог боловсронгуй болгох нь” хэлэлцүүлэг, семинарт оролцож, тусгай зөвшөөрлийн өнөөгийн нөхцөл байдал болон цаашид ямар арга хэмжээ авах талаар санал солилцов.

АНДСХАБ-ын “Хүчтэй газар хөдлөлтийг урьдчилан таамаглах цэнэгт мандлын газарт суурилсан судалгаа”, “Огторгуйн биетийг ажиглах газрын системийн сүлжээ” байгуулах төсөлд ШУА-ийн Одон орон, геофизкийн судалгааны төв хамтран ажиллах боломжийг гаргаж өгснөөр цаашид тус байгууллага хамтран ажиллахаар болов.

БШУЯ-ны Шинжлэх Ухаан Технологийн сантай 11 дүгээр сарын 11-ны өдөр хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурав, цаашид уг сантай хамтран ажиллах талаарх гэрээний төсөл дээр харилцан тохиролцож, хэрэгжүүлхээр төлөвлөөд байна.

Хоёр. Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны салбарын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилгод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэл, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах

Монгол Улсын Ерөнхий сайдын 2013 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 151 дугаар захирамжаар Банк санхүүгийн байгууллагын Банк, санхүүгийн байгууллагын мэдээллийн технологийн шинэ техник, технологи, цахим үйлчилгээг (хэтэвч, вертуал банк, мобайл банк гэх мэт) нэгдсэн зохион байгуулалтанд оруулах, төр, хувийн хэвшил, иргэдэд хүртээмжтэй шинэ үйлчилгээг нэвтрүүлэх зорилгоор төлбөр тооцоонд интернэт, утасгүй холбооны технологийг ашиглах эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаа. Ажлын хэсэгт Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороо, Харилцаа холбооны зохицуулах хороо, Арилжааны 14 банк, үүрэн холбооны 4 оператор, ББСБ, Мост Мони ПСП ХХК-ын төлөөллүүд оролцож ажиллаа. Ажлын хэсгийн удирдамжийн хүрээнд нийт 7 удаа хэлэлцүүлэг уулзалт зохион байгуулан цахим болон мобайл төлбөр тооцооны өнөөгийн нөхцөл байдал, тулгарч буй бэрхшээл, төлбөр тооцооны дундын төвийн үйл ажиллагааны талаар ярилцлаа. Мөн банк хоорондын бага дүнтэй мөнгөн гүйлгээ онлайн горимд хэрхэн явагдаж байгаатай танилцах зорилгоор Монгол банкны Үндэсний цахим гүйлгээний төвийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан Ерөнхий сайдад танилцуулав.

Аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх бодлогын хүрээнд: Аялал жуулчлалын бүс нутагт шаардлагатай харилцаа холбооны дэд бүтцийг бий болгох төслийг боловсруулж, БНҮҮС-ын 2014 оны төсөвд суулгах санал хүргүүлэв.

Үйлчилгээний бизнесийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлэх бодлогын хүрээнд:

“Аймгийн төвүүдэд нийтийн үйлчилгээний утасгүй интернэтийн бүсийг /Hotspot/ байгуулах” ажлын хүрээнд 2013 онд “Сумдад өндөр хурдны өргөн зурвасын түгээх сүлжээ байгуулах” төслийн хүрээнд 21 аймгийн төв 2 дүүрэг 2 суурин газарт утасгүй интернэтийн түгээх сүлжээний дэд бүтэц байгууллаа.

“Шилэн кабелийн сүлжээнд холбогдоогүй сумдыг өргөн зурвасын сүлжээнд холбох” ажлын хүрээнд Улсын хэмжээнд шилэн кабелийн сүлжээнд холбогдоогүй үлдсэн 39 сумдын 25 нь холбогдох боломжтой бөгөөд эдгээр сумд дээр холбогдох үнийн тооцоог боловсруулав. Эдгээр сумдаас Дорнод аймгийн Баянтүмэн сумыг “Сумдад өндөр хурдны өргөн зурвасын түгээх сүлжээ байгуулах” төслийн хүрээнд шилэн кабелиар холбосон, мөн Борнуур сумыг Мобиком ХХК өөрийн сүлжээгээр холбосон байна.

Эрүүл чийрэг Монгол хүн бодлогын “Бүх аймаг, дүүрэг, зарим сумдад телемедицины үндэсний сүлжээний дэд бүтцийг өргөжүүлэх” ажлын хүрээнд Монгол улсын хэмжээнд 2010 онд 118 сумдын эмнэлгийг шилэн кабелийн сүлжээнд холбож суурь төхөөрөмжөөр хангаснаас 2013 онд “Сумдад өндөр хурдны өргөн зурвасын түгээх сүлжээ байгуулах” төслийн хүрээнд 52 суманд хэрэгжүүлсэн болно. Уг ажил нь тухайн сумын эмнэлэгт иж бүрэн, вэб камер бүхий 1 ш компьютерийг, сүлжээний суурь төхөөрөмжүүдийн хамт нийлүүлж, суурилуулж өгсөн бөгөөд сумын холбооны байр хүртэл шилэн кабелийн сүлжээгээр холбосон нь цаашид өргөтгөх боломж бүхий суурь дэд бүтцийг байгуулсан.

Эрх чөлөөтэй Монгол хүн бодлогын “Улаанбаатар хотод төрийн байгууллагуудыг холбосон өндөр хурдны суурь сүлжээ байгуулах” ажлын хүрээнд Уг төслийг ТЕГ -ын КАБГ хариуцан гүйцэтгэхээр болсон бөгөөд төрийн байгууллагуудыг өндөр хурдны суурь сүлжээгээр ханган ажиллаж байна. Иймд дэмжлэг үзүүлэх болон МХС ТӨК -ийн үндсэн сүлжээтэй холбоотой аливаа ажилд тус газрын мэргэжилтнүүд холбогдон ажиллалаа.

Үйлчилгээний бизнесийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлэх бодлогын “Авто тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтыг боловсронгуй болгож, орчин үеийн мэдээллийн технологийн ололтыг нэвтрүүлэн авто тээврийн хөдөлгөөнийг улсын хэмжээнд хянах төв байгуулах” ажлын хүрээнд нэгдүгээр үе шат болох “Тээврийн Удирдлага, хяналтын төв”-ийг ашиглалтад оруулж тусгай дугаарын үйлчилгээ, шилэн кабелийн сүлжээнд холбогдох, интернетийн үйлчилгээ ашиглах талаар холбогдох газруудтай хамтран ажиллахаар болоод байна.

Аймгийн төвд төрөөс иргэдэд үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын орчныг утасгүй интернетийн бүсэд хамруулах бодлогын хүрээнд: Нийслэлийн 3 дүүрэг, 21 аймгийн төвд нийтийн үйлчилгээний утасгүй интернетийн бүсийг байгуулж, үйлчилгээг оруулаад байна.

“Сумын төвийн шинэчлэл” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэх бодлогын хүрээнд:

Орон нутагт мэдээлэл, холбооны нэг цэгийн үйлчилгээний төв байгуулах ажлын хүрээнд нийт 6 аймгийн 8 суманд байгуулагдсан барилга цамхаг, тоног төхөөрөмжийг ашиглалтад хүлээлгэн өгөөд байна.

Сумдад өргөн зурвасын түгээх сүлжээ байгуулах ажлын хүрээнд 52 сумын төвд эмнэлэг, ЗДТГ-ыг шилэн кабелийн сүлжээнд холбон дотоод LAN сүлжээг зохион байгуулах, шинэчлээд байна.

БШУЯ -наас Шинэ зуун төслийг хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа бөгөөд уг төслийн хүрээнд Монгол Улсын бүх хот, аймаг, сумдын сургуулиудыг хамарсан мэдээллийн сүлжээ байгуулахаар ажиллаж байгаа бөгөөд уг төслийн мэргэжилтнүүд манай газартай зөвшилцөн ажиллаж, “Сумдад өндөр хурдны өргөн зурвасын түгээх сүлжээ байгуулах” төслийн давхардлыг арилгасан болно.

Орон нутагт “Интернэтийн үнийг бууруулж, хурдыг нэмэгдүүлэх ажлын хэрэгжилтийг хангуулахад дэмжлэг үзүүлэх” ажлын хүрээнд тус газраас интернэтийн үнийг бууруулж хурдыг нэмэгдүүлэх талаар гарч буй хүндрэлтэй асуудлуудыг цаг тухай бүрт нь нэгтгэн тулгамдаж буй асуудлын талаар хэлэлцэж цаашид сүлжээний дэд бүтцийг өргөтгөхөд сувгийн түрээс хямдруулах боломж байгаа талаар “Үндсэн сүлжээний зохион байгуулалт, найдвартай ажиллагааг хангах техникийн шийдэл боловсруулах” ажлын хэсгийн хүрээнд хэлэлцэв.

Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4, 21.5 дахь хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2012 оны 69 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Сонгуулийн ерөнхий хорооны 2013 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 46 дугаар тогтоолоор сонгуулийн автоматжуулсан системд ашиглах програм хангамж, техник хэрэгслийн ажиллагааг шалган туршиж баталгаажуулах, гэрчилгээ олгох ажлын хэсэг байгуулагдсан. Тус ажлын хэсэг Сонгуулийн автоматжуулсан систем, түүний техник хэрэгсэл, програм хангамжийг шалган туршиж, гэрчилгээ олгох ажлыг амжилтай зохион байгуулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны тогтоолын дагуу “Тусгай хэрэглээний холбооны сүлжээ байгуулах, ашиглах журам” боловсруулах ажлын хэсэгт орж ажиллан урьдчилсан байдлаар журмыг боловсруулан Засгийн газарт хүргүүлэв.

Газар хөдлөлийн гамшгаас амжиж анхааруулах систем байгуулах төслийн хүрээнд: “Газар хөдлөлийн гамшгаас амжиж анхааруулах систем байгуулах төсөл”-ийн 2012-2013 онд төслийн гүйцэтгэгч талаас нийлүүлж суурилуулсан бараа материал, тоног төхөөрөмж, програм хангамжийн гүйцэтгэлд цаг тухай бүрт нь хяналт тавиж цаг хугацаанд нь ажлын хийлгэж хүлээж авах ажлыг зохион байгууллаа. Үүнд.

Системийн удирдлагын төвийн ажил

Удирдлагын төвийг байгуулан, тоног төхөөрөмжийн угсралтын ажлыг 2013 онд хийж гүйцэтгэх даалгаврын дагуу бүрэн хийж дуусгасан байна. Удирдлагын төвөөс хэт богино долгионы радио болон хиймэл дагуулын холболтыг ашиглан Улаанбаатар хотод суурилуулсан дөчин дуут дохиоллын цамхагт дохио дамжуулж, гурван телевиз болон таван ФМ радиогийн шууд эфирийг өөрчлөн туршилтын сигналыг илгээн шалгаж үзэв.

Дуут дохиоллын цамхаг

2013 онд дуут дохиоллын 3 метрийн өндөртэй цамхгийг 32 сонгосон барилга дээр, 8 метрийн өндөртэй 8 цамхгийг газарт суурилуулан иж бүрэн угсарч дууссан байна. Комиссын гишүүд шаардлагатай гэсэн байршилд дуут дохиоллын цамхгийн ажиллагааг шалгах зорилгоор дуу тоглуулж шалгаж үзсэн болно. Мөн зарим цамхгуудад нэмж хийх шаардлагатай ажлуудыг төслийн гүйцэтгэгч талд мэдэгдэн хийлгүүлсэн.

Цаг уур орчны шинжилгээний газар

Цаг уур орчны шинжилгээний газрын мэдээллийн системийг удирдлагын төвтэй холбох тоног төхөөрөмжийг байршуулж ОБЕГ дахь удирдлагын төвтэй шилэн кабелийн холболт хийгдсэн байна.

Зарлан мэдээлэх телевиз, радиогын систем

Төслийн даалгавар болон зарлан мэдээлэх төхөөрөмжийг суурилуулах байгууллагуудын (МҮОНТ 1-р суваг, Mongol HD, UBS телевиз, МҮОНР 1-р суваг 102.5, 104.5, Авто радио 96.3, Лавайн эгшиг 95.7 ФМ радио) шаардлагын дагуу холболтыг хийж гүйцэтгэв.

Шилэн кабелийн холболт

ОБЕГ – ЦУОШГ болон ОБЕГ- Хиймэл дагуулын холболтын станцыг холбосон нийт 10 км шилэн кабелийн угсралт, суурилуулалтын ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн.

Дахин дамжуулах станц болон хиймэл дагуулын холболт

Хэт богино долгионы дахин дамжуулах станцыг МҮОНРТ- дамжуулах байгууламжийн антены цамхагт (145 болон 150 метрийн өндөрт), РТСГ-ын харьяа Чингэлтэй хайрхан уул дээр байрлах дахин дамжуулах төв станцид хэт богино долгионы суурин станцуудыг ОБЕГ, дөчин дууд дохиоллын цамхгууд, таван ФМ, гурван ТВ, ЦУОШГ зэрэг газруудад суурилуулсан байна. Хиймэл дагуулын ВиСАТ-ын терминалуудыг дууд дохиоллын цамхгууд, 3 телевиз, 1 ФМ радиод суурилуулсан.

1111 дуудлага хүлээн авах төвийн

Төслийн хүрээнд Улаабаатар хотод санал хүсэлт хүлээн авах 1111 төвийг бий болгож дуудлага хүлээн авах системийн тоног төхөөрөмж 6 операторын албан хэрэгцээний тоног төхөөрөмжийг бүрэн нийлүүлж ашиглалтанд оруулсан

“Цахим засаглалын мэдээллийн сан, мэдээллийн системийг хөгжүүлэх” ТН-09/12 багц-1 буюу Монгол хэлний зөв бичгийн алдаа шалгах систем байгуулах:

Төрийн албаны бүх түвшинд гарч байгаа бичиг баримтууд хэл зүйн дүрмийн хувьд алдаагүй байхад мэдээлэл технологийн сүүлийн үеийн арга техникийг ашиглах, Үг үсгийн алдаанаас гарч байгаа эдийн засгийн үргүй зардлыг багасгахын тулд төрийн албаны бүх түвшинд энэхүү програм хангамжийг ашиглах зорилгоор бий болгосон.

Уг төсөл хэрэгжсэнээр хот хөдөөгийн төрийн байгууллагуудын бүх түвшинд гарч байгаа баримт бичгүүд үг үсгийн алдаагүй гардаг болох ба алдаанаас болж гардаг нэмэлт зардлыг бууруулах цаашид энэхүү програмыг компьютер ашигладаг хүн бүр авч хэрэглэх боломж нээгдэж байгаа юм. Төслийн хүрээнд дараах дэд системүүдийн бий болгон ашиглалтад оруулсан.

Цахим хуудас

Цахим хуудас нь шалгах текстэе нэмж оруулан алдаатай үгийг шалгах ба оновчтой үгийг санал болгох боломжтойгоор хийгдсэн.

Desktop хувилбар

Хэрэглэгч оффлайн горимд ашиглах зорилгоор desktop хувилбарыг татан авч ашиглах боломжтойгоор Windows, Linux, Mac орчний үйлдлийн систем ашиглах зорилготойгоор хийгдсэн.

Plug-in

Хэрэглэгч нь өөрийн ашигладаг Microsoft office, Libre office, Open office зэрэг програм хангамж дээр нэмэлтээр суулган ашиглах боломжтойгоор хийгдсэн

Мэдээлэл, харилцаа холбооны суурь дэд бүтцийг бий болгох, өндөр хурдны өргөн зурвасын сүлжээг байгуулах, цахим засаг, бүртгэл мэдээллийн тогтолцооны хэрэгжилтийг хангуулах

Мэдээлэл холбооны үндсэн сүлжээний өргөтгөл, шинэчлэл” төслийн хүрээнд:

- Төслийн хүрээнд 21 аймгийн 150 сумд өндөр хурдны шилэн кабелийн сүлжээнд холбогдохоос 2012 онд 4 аймгийн 30 сумдыг шилэн кабелийг ашиглалтанд оруулж, 2013 онд 16 аймгийн 72 сумдын шилэн кабель болон төгсгөлийн тоног төхөөрөмжийг байнгын ашиглалтанд оруулахад бэлэн болсон.
- Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл болон Үндэсний аудитын газраас төслийн гүйцэтгэлт хяналт, шалгалт орсон бөгөөд уг шалгалтын хүрээнд шаардлагатай төслийн холбогдох баримт, материал, мэдээллийг гарган өгч ажилласан.
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2013 оны 97-р захирамжийн дагуу төслийн 3-р багцын хүрээнд суурилуулсан шилэн кабель болон төгсгөлийн тоног төхөөрөмжийг байнгын ашиглалтанд оруулах ажлын хэсэг байгуулж 21 аймгийн 120 сумдад ажиллаж ажлын хэсгийн тайлан дүгнэлтийг нэгтгэж Ерөнхий сайдад танилцуулагдсан.
- Гэрээний дагуу БНХАУ-ын Шинжин хотод болох SDH/DWDM тоног төхөөрөмжийн сургалт болохтой холбоотой МХС ТӨК-тэй хамтарч сургалтын хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулж, МХС ТӨК-аас 7, ТЕГ-аас 1, МТШХХГ-аас 2, нийт 10 мэргэжилтэн 2013 оны 3 дугаар сарын 04-15-ны хооронд уг сургалтанд хамрагдав.
- Төслийн багц3-ын 896.776 км шилэн кабелийн суурилуулалтад харгалзах гүйцэтгэлийн санхүүжилтийг гэрээний дагуу 1.2 сая ам.долларыг гүйцэтгэгч Зэт Ти И корпорацид шилжүүлэв.
- Төслийн багц3-ын гэрээнд тусгагдсан нөөц, сэлбэг тоног төхөөрөмжийг МХС ТӨК-д хүлээлгэж өгөх комисс байгуулж Зэт Ти И корпорациас тоног төхөөрөмжүүдийг МХС ТӨК-д хүлээлгэн өгөв.
- Монгол улсын стандарт “Холбооны кабель шугамын ажлын зураг төсөл” өөрчлөгдсөнтэй холбоотой Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газартай хамтран аймаг, сумдыг холбосон шилэн кабелийн гүйцэтгэлийн зураг хийх ажлын даалгаварыг боловсруулав.

"Улаанбаатар хотын төлөвлөлттэй уялдуулан шинээр баригдаж байгаа хороолол, хотхон руу холбооны сүлжээний газрын сувагчлалын систем байгуулна" гэсэн ажлыг "Улаанбаатар хотын холбооны сувагчлалын шинэчилэл, худаг сувагчлалын цагирган сүлжээ байгуулах" төслийн хүрээнд Нийслэлийн Ерөнхий Төлөвлөгөөний Газартай хамтран шинээр баригдаж буй хороолол, дахин төлөвлөлт хийгдэж буй газрууд руу төслийн агуулгыг чиглүүлэх талаар холбогдох газрууд хамтран ажиллаж төлөвлөгөө боловсруулсан. Мөн

- ЭАТС68 -аас Үндэсний Дата Төв УТҮГ (ХШ6314 М1 2-4 худгаас ХШ6820 -ийн SB 3-5 худаг, ҮДТ-с Толгойтын эцэс L5Т 2-2 худаг хүртэл)
- ХШ419 -с ХУД -ын цагдаагийн пост
- Яармагийн гүүрний хойд талын худгаас ХУД -ийн цагдаагийн пост
- Нисэх хорооллоос Яармагийн гүүрний хойд талын худаг

- Сонсголонгийн Моносын уулзвараас Нисэх Сонсголонгийн замын уулзвар хүртэл нийт 21 км сувагчлалын ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Түүнчлэн авто замын засвар явагдаж байгаатай холбогдуулан ГХЯ -аас ЗЦГ -ын уулзвар хүртэлх замын доогуурх оруулгыг хийж гүйцэтгэлээ.

“Иргэдэд үйлчлэх нэг цэгийн үйлчилгээний төв байгуулах” төслийн хүрээнд Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Түвшинширээ, Дундговь аймгийн Адаацаг, Увс аймгийн Давст, Өндөрхангай, Хөвсгөл аймгийн Хатгал, Булган аймгийн Тэшиг, Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын иргэд харилцаа холбооны үйлчилгээг нэг цэгээс авах боломж бүрдээд байна.

“Монгол улсын аймаг сумдыг хамарсан, их багтаамжийн IP/MPLS DWDM системийг суурилуулж өндөр хурдны мэдээллийн сүлжээ байгуулах” төслийн хүрээнд нууцын төслийн хувьд холбогдох ажлуудыг гүйцэтгэсэн.

“Улаанбаатар хот болон Орхон, Дархан-Уул аймгуудийн төвүүдэд ухаалаг шуудангийн хайрцаг суурилуулах төслийг хэрэгжүүлэх” төслийн хүрээнд төслийн гүйцэтгэгч Ньюсоник ХХК нь программ хангамж болон тенхик хангамжийн ажлыг гүйцэтгэж дууссан. Улаанбаатар хотын 18 цэгт ухаалаг шуудангийн хайрцаг байрлуулахад бэлэн болоод байна.

“Сумдад өндөр хурдны, өргөн зурвасын түгээх сүлжээ байгуулах /21 аймгийн 50 суманд интернетийн үйлчилгээ хүргэхэд шаардагдах тоног төхөөрөмжнийлүүлэх/” төслийн хүрээнд 2013 онд Монгол Улсын 12 аймгийн 52 суманд "Сумдад өндөр хурдны өргөн зурвасын түгээх сүлжээ байгуулах" төслийн хүрээнд интернэтийн үйлчилгээ хүргэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийг сумын ЗДТГ, Эмнэлэгт суурилуулсан бөгөөд интернэт кафе байгуулах компьютер сүлжээг үүсгэн, утасгүй интернэтийн төхөөрөмжийг байрлуулж цаашид ашиглахад бэлэн болгосон байна.

Авто тээврийн хөдөлгөөнийг улсын хэмжээнд хянах мэдээллийн сүлжээ, төв байгуулах ажлын хүрээнд тус төвийг байгуулах гүйцэтгэгчээр Болгарын "Контракс ЕАД" компани нь ЗТЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар ажлын төлөвлөгөө батлуулан ажиллаж байна. Нэгдүгээр үе болох "Тээврийн удирдлагын хяналтын төв"-ийг 2013 оны 6 дугаар сарын 20-нд ашиглалтад оруулаад байна. Авто тээврийн хэрэгслийг улсын хэмжээнд хянах нэгдсэн сүлжээ байгуулхад МХС ТӨК-тай түрээсийн гэрээ байгуулах, ХХЗХ-оос тусгай дугаарын зөвшөөрөл авах, Цахилгаан холбоо ХХК-аас интернэтийн үйлчилгээг авч хэрэглэхэд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Аймгийн бүх багийн төвүүдийг үүрэн холбооны сүлжээгээр холбоожуулах, интернетэд холбох /Ховд/ төслийн хүрээнд гэрээний дагуу Ховд аймгийн 31 багт Үүрэн холбооны Жимобайл ХХК-ний үйлчилгээг хүргээд байна.

“Баян-Өлгий аймгийн сайтын тоон радиогийн нэвтрүүлэх станцын төслийг дуусгах, туршилтыг эхлүүлэх” ажлын зорилгын дагуу туршилт амжилттай явагдаж дууссан бөгөөд одоогоор аналог сиситемээр нэвтрүүлэг цацаж байна.

“Малчдыг холбоожуулах, алслагдсан орон нутагт харилцаа холбооны дэд бүтцийг байгуулахад шаардагдах дэд бүтцийг байгуулах” төслийн явцын хяналт шалгалтын комисст

ажиллаж холбогдох үүрэг даалгаврыг өгч Хэнтий аймгийн Галшар, Баянмөнх суманд байгуулах дэд бүтцийг байнгын ашиглалтанд оруулахад бэлэн болгов.

“Шилэн кабель суурилуулах /Хэнтий, Бор-Өндөр/” төслийн хүрээнд техникийн комисс болон БАОК –ыг байгуулж газар дээр нь хэмжилтүүдийг гүйцэтгэн акт, проктолоор холбогдох үүрэг даалгавруудыг өгч ажиллалаа.

Орон нутагт мэдээлэл холбооны нэг цэгийн үйлчилгээний төв байгуулах, Тоон радио телевизийн цамхаг байгуулах төслийн Техникийн комисст багтан ажиллаж хяналт, шалгалтыг гүйцэтгэв.

“Төрийн энтерпрайз архитектур” төслийн хэрэгжилтийг ханган ажиллахад чиглэл өгөх ажлын хэсгийн тушаалын төслийг боловсруулан батлуулж, ажлын хэсгийн ээлжит хурлуудыг зохион байгуулсан. “Төрийн энтерпрайз архитектур боловсруулах зөвлөх үйлчилгээ” төслийн 1-р үе шатны 1-р хэсгийн “Төрийн үйлчилгээний сэтгэл ханамж болон Мэдээллийн технологийн бэлэн байдлын судалгаа” , 2-р хэсгийн “Төрийн үйлчилгээний Бизнес архитектур, Програм хангамжийн архитектур, Өгөгдлийн архитектур, Технологийн архитектур”-ын судалгаа, загварчлал, 3-р хэсгийн хэсгийн Төрийн үйлчилгээг цахим портал ба мобайл технологиор хүргэх Эх систем ба Дэд системүүдийн архитектур, ажлын даалгавар, техникийн шаардлагыг тус тус боловсруулсан ажлын тайлантай танилцсан. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх үндэс суурь болсон архитектурын шийдэл нь бэлэн болсон.

“Аймгийн төвүүдэд гурвалсан үйлчилгээ нэвтрүүлэх талаар судалгаа хийх, санал боловсруулах /интернэт, суурин утас, IPTV/” төслийн хүрээнд аймгийн төвүүдэд гурвалсан үйлчилгээ нэвтрүүлэх төсөл боловсруулав.

“Улсын чанартай зам дагуу шилэн кабель суурилуулж, харилцаа холбооны хамрах хүрээг өргөжүүлэх” төслийн хүрээнд төслийг хэрэгжүүлэх техникийн тодорхойлолт боловсруулан ЭЗХЯ-нд хүргүүлсэн боловч төсвийн хязгаараас шалтгаалан 2014 онд санхүүжилт шийдвэрлэгдээгүй. БНҮҮСангийн хөрөнгөөр 2014 оноос шат дараатай үүрэн холбооны хамрах хүрээг сайжруулах төсөлд санал хүргүүлсэн.

“Үүлэн тооцооллын технологийг ашиглан цахим-оффисийн үйл ажиллагааг нэвтрүүлэх төсөл боловсруулах” төслийн хүрээнд үүлэн тооцооллын технологийг ашиглан цахим-оффисийн үйл ажиллагааг нэвтрүүлэх төсөл боловсруулав.

“Хэвлэлийн цахим хүргэлтийн системийг бий болгох төслийг шинэчлэн боловсруулах, техник эдийн засгийн тооцоог хийх, хэвлэлийн редакциудтай хамтарсан хамтарсан уулзалт хийх” төслийн хүрээнд хэвлэлийн цахим хүргэлтийн системийг бий болгох төслийг шинэчлэн боловсруулж, Зууны мэдээ сонины хэвлэлийн үйлдвэр дээр очиж хэвлэх процесттой танилцан, техник технологийн судалгаа хийж, шийдлийг боловсруулан 2013 оны төсөвт суулгах саналтайгаар удирдлагад танилцуулсан.

“Иргэдэд үйлчлэх нэг цэгийн үйлчилгээний төв байгуулах/аймаг,нийслэл/-ийн төслийн хүрээнд:

- МТҮП-ийн Компьютер сервер, сүлжээний тоног төхөөрөмж нийлүүлэх төслийн дагуу гүйцэтгэгч байгууллага болох Интерактив ХХК болон МТҮП-ийн ажлын хэсэг нийт 4 удаа уулзалт хийж гэрээний дагуу бараа материалаа 100 хувь нийлүүлж хүлээн авч, санхүүлжилтийн эрх нээлгэхээр Сангийн яаманд хүсэлтээ хүргүүлсэн.
- МТҮП-ийн Эд хогшил нийлүүлэх гүйцэтгэгч байгууллага болон Анун ХХК болон МТҮП-ийн ажлын хэсэгтэй нийт 5 удаа хуралдаж Эд хогшлийг 100 хувийн гүйцэтгэж ажлын комисс хүлээн авсан. Санхүүлжилтийн эрх нээлгэхээр Сангийн яаманд хүсэлтээ хүргүүлсэн.
- МТҮП-ийн Элкетрон систем нийлүүлэх гүйцэтгэгч компани Сайн интернэшнл ХХК нь 100 хувь бараа материал нийлүүлж ажлын комисс хүлээн авсан. Санхүүлжилтийн эрх нээлгэхээр Сангийн яаманд хүсэлтээ хүргүүлсэн.
- МТҮП-ийн Их засварын ажил хийгдэж байгаа. Гүйцэтгэгч компанийн засварын ажлын явц 80 хувьтай байна. Санхүүлжилтийн эрх нээлгэхээр Сангийн яаманд хүсэлтээ хүргүүлсэн.
- МТҮП-ийн Аудио болон видео бичлэгийн студийн тоног төхөөрөмж нийлүүлэх ажил хийгдэж байна.

“Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтанд оруулах дүрэм”-ийн нарийвчилсан журмын төслийг холбогдох мэргэжилтнүүдийн хамт бэлдэв. Барилга, хот байгуулалтын яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын болон МХЕГ-ын мэргэжилтэнтэй уулзаж чиглэл авсан. Тус яаманд ЗГ-ын 151 дүгээр тогтоолд нарийвчлан тусгах шаардлагатай байгаа ажлуудыг тодорхой тусган журмын төсөл дээр хамтран ажиллах талаар албан бичиг болон харилцаа холбооны байгууламж, инжнерийн шугам сүлжээний талаар журамд оруулах нарийвчилсан заалтуудад санал хүргүүлэв.

“Архангай аймгийн төвийн холбооны худаг сувагчлалын байгууламжийг сэргээн засварлах, өргөтгөн шинэчлэх” төслийн танилцуулгыг боловсруулсан.

Тус салбарт 2014 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 17 төслийн 70 орчим тэрбум төгрөгийн санхүүжилтыг Улсын төсөв тусгуулахаар саналаа ЭЗХЯ, ЗГХЭГ-т тус тус хүргүүлсэн бөгөөд төсвийн хязгаараас шалтгаалан 36,3 тэрбум төгрөгийн 13 төслийг хэрэгжүүлэхээр болсон.

Ерөнхий сайдын 2013 оны “Хүн шиг амьдарч улс шиг хөгжих” ажлын төлөвлөгөөний 9 дүгээр сард хэрэгжүүлэх үйл ажиллагааны “Ургац хураалт” хэсгийн “Улаанбаатар хотод хэрэглэх үнэгүй WIFI интернетийн бүс байгуулах” зорилтын дагуу Нийслэлийн цэцэрлэгт хүрээлэн, улсын нэгдсэн эмнэлэгүүд, улсын их сургуулиудын өмнөх талбай, дүүргийн цэцэрлэгт хүрээлэнгүүдэд утасгүй интернетийн бүс байгуулах ажилд холбогдох төрийн байгууллагуудаас зөвшөөрлүүдийг олгуулж хамтран ажиллав

Дүнжингарав хаврын бүсийн уралдааныг зохион байгуулах ажилд харъяа байгууллагууд, зурагт, радиогийн байгууллагуудыг нэгтгэсэн зохион байгууллалтаар оролцуулж шууд дамжуулалтыг хийх, утасгүй интернэтийн бүс үүсгэх ажилд хамтран оролцов.

Шинээр баригдах барилга байгууламж, орон сууцны хорооллын харилцаа холбооны дэд бүтцийг сайжруулах ажлын хүрээнд холбогдох байгууллагууд, Нийслэлийн ерөнхий

төлөвлөгөөний газар, Барилгын хөгжлийн төвтэй хамтран санал солилцох уулзалтыг зохион байгууллаа. Уулзалтын хүрээнд интернет болон телевизийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын хувьд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга зам болон энэхүү ажилтай холбоотой шинээр боловсруулагдаж буй стандартуудын талаарх мэдээллийг авч санал бодлоо солилцлоо.

Улсын хэмжээнд шилэн кабелийн сүлжээнд холбогдоогүй үлдсэн 39 сумдын 25 нь холбогдох боломжтой бөгөөд эдгээр сумд дээр холбогдох үнийн тооцоог боловсруулав. Эдгээр сумдаас Дорнод аймгийн Баянтүмэн сумыг "Сумдад өндөр хурдны өргөн зурвасын түгээх сүлжээ байгуулах" төслийн хүрээнд шилэн кабелиар холбосон, мөн Борнуур сумыг Мобиком ХХК өөрийн сүлжээгээр холбосон байна. Эдийн засгийн хөгжлийн яамны сайдын ТЭЗҮ -ийн багцад үлдсэн сумдыг хайгуул хийх ТЭЗҮ боловсруулах саналыг хүргүүлэв.

БНҮҮС –тай уялдаатай ажиллан интернэтийн түгээх үйлчилгээ хүргэх, шилэн кабель суурилуулах, холбооны дэд бүтэц байгуулах ажлын төлөвлөлтийг хамтран хийв. Зарим суурилуулах ажлын төсөв, тооцоог бодсон болно.

“Сумдад өндөр хурдны өргөн зурвасын түгээх сүлжээ байгуулах” төслийн хүрээнд Дорнод аймгийн МХС ТӨК –тэй хамтран тус аймгийн төвөөс 6 км зайд орших Баянтүмэн сум руу шилэн кабелийн сүлжээ татав.

МУ –ын интернэт үйлчилгээ хүрсэн сумдын талаарх мэдээллийг нэгтгэн боловсруулав.

Гурав. Төрийн захиргаа, хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, газрын үйл ажиллагаанд хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх, санхүү болон гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх

Төрийн захиргааны удирдлагын манлайлал, салбарын хүний нөөцийн бодлого боловсруулах, гадаад хамтын ажиллагааны удирдлага зохицуулалтад дэмжлэг үзүүлэх

МТШХХГ-аас олон нийт, салбар болон хэвлэл мэдээллийн байгууллагуудад танилцуулах зорилгоор Мэдээлэл харилцаа холбооны салбарт 2013-2016 онуудад хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүд болон “Шинэчлэлийн 7 зорилт” сэдэвт нээлттэй өдөрлөгийг Төрийн ордны их танхимд 2013 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр зохион байгууллаа. Өдөрлөгт бүх яам, агентлаг, төрийн болон төрийн бус нийт 150 гаруй байгууллагуудаас 900 орчим төлөөлөгчид оролцлоо.

Газар, хэлтсийн үйл ажиллагааны тайланг сар, улирал, хагас жил, жилээр нэгтгэн боловсруулж, удирдлагад танилцуулан, тайлант хугацаанд нь Засгийн газрын хэрэг эрхлэх газарт тогтмол хүргүүлж байна.

Газар, хэлтсийн албан хаагчид шат шатны үр дүнгийн гэрээ байгуулах, хэрэгжилтийг хангуулан ажиллаж ажиллаж байна.

МТШХХГ нь 2013 онд дараах үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх дүрэм журмыг боловсруулан батлуулж, мөрдлөг болгон ажиллаж байна. Үүнд

- ✚ “Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын хөдөлмөрийн дотоод журам”-ын хоёрдугаар хавсралтад “Маягт 10. Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газарт туршилтын хугацаагаар ажиллаж байгаа мэргэжилтний ажлыг дүгнэх хуудас
- ✚ Төрийн жинхэнэ албан тушаалд туршилтын хугацаа хэрэглэх болзол, журам
- ✚ МТШХХГ-ын албан хаагчдын үйл ажиллагааг үнэлэх дүгнэх журам
- ✚ МТШХХГ-ын шагналын журам

Монгол Улсад “Орчин цагийн мэдээлэл харилцаа холбооны салбар үүсч хөгжсөний 92 жил”-ийн ой, “Цахилгаан холбоо, мэдээлэлжсэн нийгмийн Дэлхийн өдөр”-ийг тус тус тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газраас 2013 оны 5 дугаар сарын 17-21-ны өдрүүдэд Мишээл экспо төвийн үзэсгэлэнгийн танхимд “Ирээдүйтэй холбогдъё-Шинэ амьдралын хэв маяг”/ Connecting the future-New life style/ уриан дор “ICT-EXPO-2013” үзэсгэлэнг 7 дахь жилдээ амжилттай зохион байгууллаа. Үзэсгэлэнд Олон улсын болон гадаадын 5 байгууллага, Мэдээллийн технологийн салбарт үйл ажиллагаа явуулж буй 60 аж ахуйн нэгж, Төрийн 5 байгууллага, Мэдээллийн технологийн дэвшлийг ашиглан үйл ажиллагаа явуулж буй уул, уурхайн компани, Холбоо мэдээллийн технологийн сургууль, 130 сайтыг эгнээндээ нэгтгэсэн сайтуудын 2 холбоо оролцож, арилжааны 7 телевиз хамтран ажиллав. Үзэсгэлэнг давхардсан тоогоор нийтдээ 66150 хүн /онлайн болон бодитоор/ үзэж сонирхсон байна. Үзэсгэлэнгийн хүрээнд “Flash mob & Harlem shake” онлайн бүжгийн тэмцээн, “ICT for Life” компьютер графикын уралдаан, Цахим спортын улсын аварга шалгаруулах тэмцээн, Хурдан бичилт, компьютер угсралтын тэмцээнийг тус тус амжилттай зохион байгууллаа. Мөн энэ үеэр ICT-EXPO-2013 үзэсгэлэнгийн “Шилдэг”-үүдийг шалгаруулж өргөмжлөлийг гардууллаа.

“Мэдээлэл, харилцаа холбооны салбарын баяр” спортын наадмыг сагсан бөмбөг, гар бөмбөг, хөлбөмбөг, дартс, ширээний теннис, цахим спорт, шатар гэсэн нийт 7 төрлөөр 5 дугаар сарын 3-наас-12-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Уг тэмцээнд 25 байгууллагын 1100 тамирчин өрсөлдөж багын дүнгээр Мобиком корпораци ХХК шалгарсан.

“Монгол Улсын Үндэсний хиймэл дагуул хөтөлбөр”-ийн зорилтын нэг болох сансрын технологи, хиймэл дагуулын ач холбогдлыг олон нийтэд тайлбарлан таниулах, дотооддоо мэргэжилтэн бэлтгэх чадавхижуулах ажлын хүрээнд 2013 оны 5 дугаар сарын 19-ний өдөр Монгол Улсын Ерөнхий Сайдын ивээл дор “КАНСАТ” сонирхогчийн хиймэл дагуул зохион бүтээж, хөөргөх Улсын анхдугаар уралдааныг амжилттай зохион байгууллаа. Тус уралдаанд Жи-Мобайл-МУИС-ийн ФЭС-ийн хамтарсан “Жи-Дагуул” баг, “Монголын Цахилгаан Холбоо” ХК - ШУТИС-ийн ХМТС-ийн хамтарсан “SICT-TELECOM” баг, “Мэдээлэл Холбооны Сүлжээ” ТӨК - ШУТИС-ийн КтМС-ийн хамтарсан “Космос” баг, Мобиком корпораци - ШУТИС-ийн МИС-ийн хамтарсан “Тэмүүлэл” баг, Юнител групп - МУИС-ийн МТС-ийн хамтарсан “Орбит” баг, Инкомнет ХХК - Батлан хамгаалах их сургууль, Хөдөө аж ахуйн их сургуулийн хамтарсан “Эхлэл” баг гэсэн нийт 7 их, дээд сургуулийн 6 баг оролцож 1-р байранд “Тэмүүлэл” баг, 2-р байранд “Космос” баг, 3-р байранд “Жи-Дагуул” баг, Тусгай номинацид “SICT-Telecom” баг шалгарлаа.

Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор Монголын програм хангамж үйлдвэрлэлийн салбарын анхдугаар чуулганыг амжилттай зохион байгууллаа. Чуулганы ажлын хүрээнд дараах ажлыг гүйцэтгэв. Үүнд:

- Чуулганы үеэр програм хангамж үйлдвэрлэгчдийг дэмжиж ажиллахаар Жижиг Дунд Үйлдвэрийн хөгжлийн сан, Шинжлэх Ухаан технологийн сан, Сургалтын төрийн сан, Оюуны өмчийн газар, Хөдөлмөрийн Яам, Боловсрол Шинжлэх Ухааны Яам, Арилжааны банкны төлөөллүүд, Уул уурхайн Үндэсний ассосиаци, Монголын програм хангамж үйлдвэрлэгчдийн холбоо, Зээлийн батлан даалтын сан, ЖАЙКА-гийн 2 үе шаттай зээлийн төсөл, Салбарын Их дээд сургуулиуд, Мэдээллийн технологийн консерциум, Монгол шуудан ТӨК, Монголын цахилгаан холбоо ХК, Мэдээлэл холбооны сүлжээ ТӨК зэрэг байгууллагуудтай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа.
- Чуулганы үеэр мэдээллийг олон нийтэд таниулах, сурталчлах ажлын хүрээнд www.chuulgan.mn www.itpta.gov.mn сайтуудаар, 16 телевиз, 3 цахим хуудас, 2 фм радио, 3 сонинтой хамтран ажиллаж, үйл ажиллагааг шууд дамжуулан, давхардаагүй тоогоор 9523 үзэгч холбогдлоо.
- Чуулганыг зохион байгуулах ажлын хүрээнд “Монгол ухаан Монгол брэнд” нэвтрүүлэгийн 2 дугаар ангийг бэлтгэн, 8 телевизээр цацалт хийлээ.
- Чуулганы ажлын үр дүнгийн талаар МТ-ийн зөвлөлөөр Ерөнхий сайдад танилцуулан, чуулганаас гарах бодлогийн зөвлөмжийн талаар хэлэлцлээ.

Газрын Даргын зөвлөлийн хурлыг тогтмолжуулж долоо хоног бүрийн Мягмар гаригт хуралдуулж байгаа ба 11 удаагийн хурлаар 18 асуудлыг хэлэлцүүлж, холбогдох шийдвэрийг баримтжуулж хэрэгжилтэнд нь хяналт тавин ажиллалаа.

Газрын нийт албан хаагчдын Хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд Мэдүүлгийн програмд цахимаар болон цаасаар хүлээн авч, Хөрөнгө орлогын мэдүүлгийн маягт, түүнийг хэрхэн бөглөх талаархи зааврыг хүргүүлсэн ба Авлигатай тэмцэх газарт албан тушаалтнуудын 2012 оны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг /хураангуй/, Мэдүүлгийн 2012 оны тайланг хүргүүлсэн. Тус газрын Авлигаас урьдчилан сэргийлэх Авлигын эсрэг 2013 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллалаа. 2013 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр төлөвлөгөөний биелэлтийг холбогдох материалын хамт Авлигатай тэмцэх газарт хүргүүлээ.

Албан хаагчдад зориулан “Мэдээллийн цаг” хөтөлбөрийг долоо хоног бүрийн Баасан гаригт төлөвлөгөөний дагуу нийт 16 удаагийн арга хэмжээ зохион байгуулж, тухайн жилийн сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг жилийн эцэст тооцон дараа жилийн сургалтын хэрэгцээг тодорхойлохоор төлөвлөөд байна.

а. Тогтоол, шийдвэрийн биелэлтийн талаар

Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын захирамжийн биелэлтийг улирал бүр гаргаж мэдээг ЗГХЭГ-т хүргүүлж байв. Гуравдугаар улирлын байдлаар нийт 26 тогтоол шийдвэрийн 29 заалтын биелэлт ... хувьтай байна. 2012 оны 4 дүгээр улирлын байдлаар тогтоол шийдвэрийн биелэлтийг гаргаж байна.

б. Өргөдөл гомдлын талаар

Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч шуурхай шийдвэрлэхтэй холбогдуулан санал, хүсэлтийн хайрцаг нээн ажиллуулж байна. Тус газарт 2013 оны 11 дугаар сарын 15-ны өдөр хүртэл хугацаанд иргэдээс 8 газрын албан хаагчдаас 48 нийт 56 өргөдөл ирснийг хүлээн авч бүртгэн холбогдох албан тушаалтанд шилжүүлэн зохих хууль журмын дагуу шийдвэрлэлээ.

Шинэчлэлийн Засгийн Газар “11-11 ТӨВ”-ийг байгуулж иргэддээ нээлттэй, тунгалаг төрийг цогцлоохын тулд хүнд суртлыг халж, хурдан шуурхай үйлчилгээг эрхэмлэж, иргэдийн саналыг арван сувгаар хүлээн авч, хариулт өгөхөөр үйл ажиллагаагаа эхлээд байгаатай холбогдон иргэдээс мэдээллийн технологийн чиглэлийн нийт **342** талархал, гомдол, шүүмжлэл, санал хүсэлт ирүүлснийг хүлээн авч, тухай бүрт нь шуурхай шийдвэрлэн, холбогдох арга хэмжээг авч, ажиллаж байна.

в. Архив албан хэрэг хөтлөлтийн талаар

Газрын албан хэрэг хөтлөлтийг Албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврыг мөрдлөг болгон ажиллаж ирлээ. Архивын ажлын үндсэн заавар, Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар мөрдлөг баримт бичгүүдийн бүрдэл бүрэн эсэх, бүрдэл тус бүрт тавигдах шаардлагыг ханган ажиллалаа.

Тус газарт ирсэн баримт бичгийг хүлээн авах, бүртгэх, явуулсан бичгийг бүртгэх, өргөдөл гомдлыг бичиг хэргийн бүртгэл, хяналтын программд бүртгэн хяналтын карт хөтлөн баталгаажуулан ажиллаж ирлээ.

Агуулга	Тоо хэмжээ
Тус газарт ирсэн бичиг	1175
Үүнээс карттай хариу явуулсан	
Тус газраас явуулсан албан бичиг	1515
Шууданд хаяглаж, дугтуйлж	
Хүлээлгэн өгсөн баримт бичгийн тоо	
Газрын даргын тушаал	298
Дээд газраас ирүүлсэн шийдвэр, тэмдэглэл	
Иргэд, ажиллагсдаас ирүүлсэн өргөдөл	56
Хариуг явуулсан болон хаасан	56
Бүгд	

Шуурхай зөвлөгөөний тэмдэглэлийг хөтөлж, тухай бүрт нь холбогдох хэлтсүүд харъяа байгууллагуудад хүргүүлж, нийт 44 удаагийн шуурхай зөвлөгөөний давхардсан тоогоор нийт 672 гаруй үүрэг, даалгаврын хэрэгжилтийг хангуулан ажиллав.

Монгол Улсад орчин цагийн харилцаа холбоо үүсч хөгжсөний 92 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан тус газрын харъяа болон салбарын байгууллагуудаас, “Хөдөлмөрийн Гавъяаны Улаан Туг”-ийн одонгоор 3, “Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар 16, “Алтан гадас”- одонгоор 10 хүнийг тус тус шагнуулахаар тодорхойлсон материалуудыг холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлснээс нийтдээ 29 хүн төрийн дээд одон медалиар шагнагдав. Мөн тус салбараас төрийн дээд шагналд дэмжлэг хүссэн 56 материал хүлээн авч саналаа холбогдох байгууллагууд руу хүргүүлэв

Мэдээлэл, харилцаа холбооны салбарын тэргүүний ажилтан цол тэмдгээр 353, жуух бичгээр 160, хүндэт холбоочин цолоор 122 шуудангийн тэргүүн 36 хүнийг шагнах ажлыг зохион байгуулав.

Санхүүгийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, салбарын үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчлах

г. Төсөв санхүүгийн талаар

Үндэсний аудитын газраас МТШХХГ-ын 2012 оны санхүүгийн тайлан бланс, худалдан авах үйл ажиллагаанд худалдан авах үйл ажиллагааг шалгаж, шалгалтын дүнгээр “хангалттай” үнэлгээг авлаа.

Тус газраас ЗГХЭГ, Төрийн өмчийн хороонд Бараа ажил үйлчилгээ худалдан авалтын 2012 оны жилийн эцсийн тайлан, 2013 оны эхний хагас жилийн тайлан, 2014 онд үндсэн хөрөнгөнд нэмж худалдан авах техник, тоног төхөөрөмжийн санал, төлөвлөгөөг боловсруулан ЗГХЭГ, СЯ-д тус тус хүргүүллээ.

Газрын 2013 оны комиссыг байгуулж байгууллагын техник, тоног төхөөрөмж, эд хөрөнгийн тооллогыг хийж бүртгэлийн карт хөтлүүлэн эзэнжүүлэх ажлыг зохион байгууллаа.

Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны салбарын хуульчдын уулзалтыг зохион байгуулав.

Засгийн газрын хуралдааны 5 дугаар тэмдэглэлийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд МТШХХГ болон холбогдох газруудын төлөөлөгчид АНУ-ын Вашингтон хотноо 3 сарын 18-21-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “Satellite 2013” олон улсын хурал, үзэсгэлэнд оролцлоо. Уг арга хэмжээ нь Дэлхийн 350 гаруй байгууллагууд, 12000 гаруй төлөөлөгчид оролцсон томоохон арга хэмжээ болсон бөгөөд манай төлөөлөгчид харилцаа холбооны хиймэл дагуул үйлдвэрлэгч, хөөргөгч, даатгагч, оператор, эрсдлийн менежмент, зөвлөх үйчилгээ үзүүлэгч чиглэлээр 20 гаруй уулзалтуудыг амжилттай зохион байгууллаа. Арга хэмжээнд оролцож, уулзалтууд хийсэн талаар Ерөнхий Сайдад танилцуулга хийв. Уулзалтын үед дэлхийд тэргүүлэгч нийт 16 компанид хамтран ажиллах боломжийн талаар санал солилцох уулзалтын урилга, техникийн шаардлагын хамт хүргүүлсэнээс АНУ-ын Boeing Satellite System International, Итали-Францын хамтарсан Thales Alenia Space, Европын холбооны Atrium, хиймэл дагуул хөөргөлтийн үйлчилгээний чиглэлээр дэлхийд тэргүүлэгч Францын Arianespace, АНУ-ын SpaceX, ОХУ-АНУ хамтарсан ILS, мөн харилцаа холбооны хиймэл дагуулын үйлчилгээ эрхлэгчдээс АНУ-ын Intelsat, SES, Канадын Telesat, өргөн нэвтрүүлгийн оператор компани болох Asia Broadcasting Satellite зэрэг нийт 10 компани оролцохоо мэдэгдэж 2013 оны 4 дүгээр сарын 15-наас 22-ны өдрүүдэд Монгол Улсын Гадаад харилцааны яамны “Зөвшилцөл Танхим”-д дээрх компаниудын төлөөллүүдтэй уулзалтуудыг зохион байгууллаа. Уулзалтуудад Монголын талаас МТШХХГ, холбогдох яамдын төлөөлөгчид болон Сансрын үндэсний зөвлөлийн гишүүд оролцов. Дээрх уулзалтуудын бэлтгэл ажлыг хангах, үр дүнг нэгтгэн танилцуулах талаар Сансрын үндэсний зөвлөлийн хурлуудыг тогтмол зохион байгуулан ажилласан.

Монгол Улсын Үндэсний Хиймэл Дагуул Хөтөлбөрийн хүрээнд зөвлөгөө өгөхөөр 2013 оны 6 дугаар сарын 6-наас 15-ны өдрүүдэд ОУЦХБ-ын Сансрын асуудал эрхэлсэн хэлтсийн дарга Хэнри Ивон, ОУЦХБ-ын Ази-номхон далайн бүсийн төвийн зөвлөх Ашиш Нараян болон ОУЦХБ-ын зөвлөх Аврам Сион нар тус газарт хүрэлцэн ирж ажиллалаа. Энэ үеэр ОУЦХБ болон ХХЗХ, МХС ТӨК-тай хамтран Олон улсын радио давтамжийн төлөвлөлт сэдэвт 1 өдрийн сургалт семинарыг 2013 оны 6 дугаар сарын 7-ны өдөр МХС ТӨК-ны байранд салбарын төрийн болон хувийн хэвшлийн нийт 52 мэргэжилтэн оролцож амжилттай зохион байгуулав. Тус сургалт семинарт МХХТ-ийн ХХЗХ-той хамтран ОУЦХБ-ын Хөгжлийн болон Радиогийн салбарын үйл ажиллагааны талаар танилцуулах хагас өдрийн семинарыг 2013 оны 6 дугаар сарын 10-ны өдөр ХХЗХ-ны байран дээр зохион байгууллаа. Тус албаны хүмүүсийн Монгол Улсад ажиллахтай холбоотой болон семинар зохион байгуулахтай холбоотойгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Нэгдсэн үндэстний байгууллагын Сансрын уудмын асуудал эрхэлсэн нэгж (United Nations Office for Outer Space Affairs)-ийн Сансар Огторгуйг Энхийн Зорилгоор Ашиглах Хороо (Committee on the Peaceful Uses of Outer Space)-ны гишүүнээр манай улс 1961онд бүртгэгдсэн ба тус Хорооны 56 дугаар хурал 2013 оны 6 дугаар сарын 12-ноос 21-ний өдрүүдэд Австрийн Вена хотноо зохион байгуулагдах юм. Тус Хорооны 56 дугаар хуралд Монгол Улсаас Вена хот дахь олон улсын байгууллагуудын дэргэд суугаа Байнгын төлөөлөгчийн газраас төлөөлөгч оролцуулан хурлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахаар ГХЯ-нд хүсэлтээ илгээгээд байна.

Кибер гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын конвенци, гэрээ хэлэлцээрт нэгдэн орох, гадаад харилцаа хамтын ажиллагааг хөгжүүлэх ажлын хүрээнд Кибер аюулгүй байдлын газартай хамтран судалгаа хийсэн. НАТО олон улсын байгууллагатай мэдээллийн аюулгүй байдал чиглэлээр хамтран ажиллах судалгаа хийж, БХЯ, ЗХЖШ-тай хамтран ажиллах саналаа илэрхийлж, уулзалтуудад оролцов. Мөн 2001 оны 11-р сарын 23 нд Будапешт хотноо батлагдсан хүчин төгөлдөр үйлчилж буй Цахим гэмт хэргийн тухай олон улсын конвенцид нэгдэн орох наад захын шаардлага бол Цахим гэмт хэргийн хуулийн зохицуулалттай байх асуудал юм. Мөн Малайз улсын Куала Лампур хотноо 2013 оны 12-р сарын 3-5-ны өдрүүдэд АРТ, Малайзын Мультимедиа, Харилцаа холбооны яамтай хамтран зохион байгуулсан Азийн орнуудын Кибер аюулгүй байдлын форум үеэр IMPACT, ICANN олон улсын байгууллагатай хамтран ажиллах тухай саналаа илэрхийлэв.

Итали улсын тоон өргөн нэвтрүүлгийн техник технологи, тоног төхөөрөмжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Elettronika Group, Syes, Rai Way зэрэг компаниудтай хамтран DVB-T2, DRM стандартууд, тоон телевиз, радиогийн өргөн нэвтрүүлгийн сүлжээний бүтэц, техник, технологийн давуу талууд мөн Монгол улсын тоон өргөн нэвтрүүлгийн шилжилтийн явцын талаарх мэдээллүүдийг холбогдох байгууллага, компаниудын мэргэжилтэн, инженер техникийн ажилчдад хүргэх зорилгоор Тоон өргөн нэвтрүүлгийн семинарыг 2013 оны 2 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулсан.

"Тоон ТВ өргөн нэвтрүүлэг" инженерийн сургалт 2013 оны 2 дугаар сарын 20-ны өдөр 2013 оны 10 дугаар сарын 18-ны өдөр зохион байгууллаа. Сургалтад Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар, Харилцаа холбооны зохицуулах хороо, Радио телевизийн сүлжээ

УТҮГ болон кабелийн телевиз, эфирийн телевиз, IPTV, эрдэм шинжилгээний байгууллага гэх мэт нийт 26 байгууллагын 80-аад инженер техникийн ажилтан, албан хаагчид оролцсон.

Ази-номхон далайн сансрын хамтын ажиллагааны байгууллагын 2013 оны “Сансрын хэрэглээний хөтөлбөр”-ийн хүрээнд олгож буй “Байршил тогтоох хиймэл дагуул”, “Зайнаас тандан судалгаа болон газарүйн мэдээллийн систем”-ийн чиглэлээр магистрийн зэрэг олгох тэтгэлэгт хөтөлбөр болон “Сансрын технологи болон түүний хэрэглээ”-ний чиглэлээр докторын зэрэг олгох тэтгэлэгт хөтөлбөрийн сонгон шалгаруулалтыг олон нийтэд нээлттэй зарлан, магистрийн хөтөлбөрт 4, Докторын хөтөлбөрт 1 хүн тэтгэлэг авч суралцаж байна.

Ази номхон далайн сансрын хамтын ажиллагааны байгууллага (APSCO)-тай хамтран "Бага оврын хиймэл дагуул хөгжүүлэлт" сэдэвт олон улсын сургалтыг Улаанбаатар хотноо анх удаа 2013 оны 9 дүгээр сарын 10- наас эхлэн дөрөв хоногийн хугацаатай зохион байгууллаа. Сургалтын хүрээнд Иран, БНХАУ, Пакистан, Монгол зэрэг улсуудын эрдэмтэн, судлаачид бага оврын хиймэл дагуул хөгжүүлэх техник, технологийн сэдвээр лекц уншин, сургалт явуулах юм. Сургалтанд Бангладеш, БНХАУ, Турк, Тайланд, Иран, Пакистан, Индонез, Перу зэрэг улсын 40 гаран төлөөлөгч оролцсон.

Дөрөв. Статистик мэдээ, мэдээллийн хэрэгцээг хангах, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, мэдээллийн аюулгүй байдалд хяналт тавьж удирдамж зөвлөмжөөр хангах.

Салбарын статистик мэдээ гаргах, мэдээллийн сан байгуулах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах

Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийн 5 дах илтгэл бэлтгэх ажлын хүрээнд тус салбарт хамаарах зорилтын 2011-2012 оны тайланг гаргаж, Эдийн Засгийн Хөгжлийн Яаманд хүргүүлэв.

Мэдээллийг цахим хэлбэрт оруулж, мэдээллийн санг үүсгэх, түгээх, ашиглах, түүний байнгын тасралтгүй үйл ажиллагаа, хадгалалт, хамгаалалтын найдвартай байдлыг хангах нийтлэг журмын төслийг Тагнуулын Ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар, Мэдээлэл технологийн үндэсний парк, Үндэсний дата төв зэрэг холбогдох газруудаас санал авч эцэслэн боловсруулж Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн бөгөөд ЗГХЭГ-т хүргүүлсэн.

Хууль тогтоомж, гэрээ хэлэлцээр, хөтөлбөр, төслийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх

Шинээр батлагдсан гарч буй “Хаягжилтын тухай хууль”-ийг хэрэгжүүлэх ажлын хэсэгт хаягийн журам, мэдээллийн сангийн чиглэлээр ажиллаж байна. Энэ хүрээнд Дэлхийн банкны зөвлөмжийн орчуулгыг хянаж ажиллав.

Мэдээллийн технологи, харилцаа холбооны салбарт 2012 онд хэрэгжүүлсэн болон одоо хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдэд хяналт-шинжилгээ хийж төсөл тус бүрээр тайлан гаргалаа.

Тус агентлагаас хариуцан хэрэгжүүлж байгаа үндэсний хөтөлбөрүүдийн 2012 оны хэрэгжилтийн товчоог холбогдох дүрэм, журмын дагуу гаргаж ЗГХЭГ-т хүргүүллээ.

“Сумдад өндөр хурдны өргөн зурвасын түгээх сүлжээ байгуулах” ТН-03/12 төслийн гүйцэтгэлийг хүлээн авах ажлын хүрээнд тус газрын мэргэжилтнүүд техникийн болон улсын комиссын бүрэлдэхүүнд томилогдож 2013 оны 01, 03 дугаар сард Хэнтий, Сүхбаатар, Дорнод аймгуудын 12 суманд ажиллалаа.

“Архангай аймгийн 16 багийг Жи мобайл сүлжээгээр холбоожуулах” төслийн гүйцэтгэлийн явцыг 2013 оны 01 дүгээр сард, “Орон нутгийн мэдээлэл холбооны нэг цэгийн үйлчилгээний төв байгуулах”, “Орон нутагт тоон радио, телевизийн цамхаг барих” төслүүдийн гүйцэтгэлийг хүлээн авах ажлын хүрээнд тус газрын мэргэжилтнүүд техникийн болон улсын комиссын бүрэлдэхүүнд томилогдож 2013 оны 01, 03 дугаар сард Төв аймгийн Зуунмод хот, Батсүмбэр сум, Дундговь аймгийн Адаацаг сум, Архангай, Завхан, Увс, Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Баянхонгор, Өмнөговь аймгуудад ажиллалаа.

Төсөл хөтөлбөрийн гүйцэтгэлтэй холбогдох асуудлаар “Орон нутгийн мэдээлэл холбооны нэг цэгийн үйлчилгээний төв байгуулах” ТН01-10 төслийн гүйцэтгэгч Спейшл ХХК-тай уулзалт хийж гүйцэтгэлийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулахаар болсон ба тус төслийн явцын ерөнхий мэдээллийг гаргасан.

“Орон нутагт тоон радио, телевизийн цамхаг барих” төслийг гүйцэтгэлийг байнгын ашиглалтанд хүлээн авах ажлын хүрээнд тус газрын мэргэжилтнүүд улсын комиссын бүрэлдэхүүнд томилогдож 2013 оны 4 дүгээр сарын 1 өдөр Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум, 19-20-ны өдрүүдэд Дорноговь аймгийн Сайншанд сум, 15-22-ны өдрүүдэд Завхан, Хөвсгөл аймагт тус тус ажиллав.

“Малчдыг холбоожуулах, алслагдсан орон нутагт харилцаа холбооны үйлчилгээг хүргэх /Хэнтий, Галшар, Баянмөнх/” төслийн хүрээнд Хэнтий аймгийн Галшар, Баянмөнх сумдад төслийн гүйцэтгэлийг хүлээн авах Улсын комиссын бүрэлдэхүүнд ажиллав.

“Хөдөөгийн алслагдсан сум, багийн иргэд, малчдыг үүрэн холбооны Жи-мобайл сүлжээний өргөтгөлөөр бүрэн холбоожуулах, интернэтжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд Хөвсгөл аймгийн үүрэн холбооны төслийг хэрэгжилтийг газар дээр нь ажиллаж шалгав.

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгөөр Мобиком корпораци ХХК-ийн хэрэгжүүлсэн “Орон нутагт үүрэн холбооны үйлчилгээ хүргэх” ТН:36/12 тоот төслийн гэрээнд заагдсан Өвөрхангай аймгийн Уянга сумын Жаргалант багт хийсэн ажлын гүйцэтгэлийг шалгах техник, хяналтын ажлын хэсэгт 2013 оны 7 дугаар сарын 3-4-ний өдрүүдэд тухайн газар дээр нь ажиллаж тайлан гаргаж хянан баталгаажуулсан.

БНҮҮСангийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Хөдөө орон нутагт үүрэн холбооны үйлчилгээ хүргэх” төслийн явцыг Баянхонгор аймгийн Галуут сум Мандал баг, Эрдэнэцогт сум Тамчи баг, Баянцагаан сум Аргалант баг зэрэг газруудаар явж шалгалаа. Шалгалтын ажлын хүрээнд Хөвсгөл, Булган, Баянхонгор аймгуудын комиссийн дүгнэлт гараад байна.

Монгол Улсын телевизийн өргөн нэвтрүүлгийг аналого системээс тоон систем рүү шилжүүлэх төслийн хүрээнд нийлүүлж, суурилуулсан тоон телевизийн тоног төхөөрөмжийг байнгын ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд орж 2013.10.21-11.12-ны хугацаанд Төв, Хэнтий, Дорнод, Сүхбаатар зэрэг 7 аймгийн 38 сумдад ажилласан.

Хөдөө орон нутгийн салбарын удирдлага, мэргэжилтэнүүдтэй хийсэн видео хуралд салбарын өнөөгийн байдлын талаар материал бэлтгэж үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ болон стандартын ажлын талаар мэдээлэл хийв.

Өндөр хурдны өргөн зурвасын үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж тайлан гаргасан ба дотоод мэдээллийн системд 2013 оны эхний хагас жилийн байдлаар гаргаж ASU office програмд оруулсан.

Монгол Улсын төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр мэдээлэл, харилцаа холбооны улс, хот хоорондын дамжуулах сүлжээ, хотын доторх сүлжээг өргөтгөх зорилгоор 2005 оноос хойш тус газрын байгуулсан сүлжээг Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК-ийн өмчлөлд шилжүүлэх ажлыг хянан, зохион байгуулах ажлын хүрээнд “Үндсэн сүлжээний нөөц төв байгуулах” багц төсөлд /11 төсөл/ хянан судалж дүгнэлт гаргалаа.

Үндэсний хиймэл дагуул хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж байна. Энэ ажлын хүрээнд хөтөлбөрийн төлөвлөгөөний биелэлтийг гаргуулж, холбогдох мэдээллүүдийг нэгтгэн судалж хэрэгжилтийн талаарх танилцуулга бэлтгэж байна.

Радио, телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон системд шилжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж тайлан гаргаад байна.

Гамшгаас амжиж анхааруулах систем байгуулах төслийн хэрэгжилийн явцтай 8, 11 дүгээр сард танилцаж явцын тайланг баталгаажуулав.

Салбарын бодлого, төлөвлөгөөний биелэлт гаргах, байгууллагын дотоод үйл ажиллагааны үр дүн болон мэдээллийн аюулгүй байдалд хууль тогтоомжийн дагуу хяналт тавих

Улсын 2014 оны төсөвт суулгах төсвийн төлөвлөгөө, саналыг холбогдох чиглэлээр боловсруулж нэгдсэн саналд тусгуулсан.

Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний шалгуур үзүүлэлтийг гаргасан ба төлөвлөгөөний хэрэгжилтийг 2012 оны байдлаар гарган ЗГХЭГ-т хүргүүлэв. Мөн төлөвлөгөөний тус салбарт хамаарах арга хэмжээнүүдийг ASU office системд оруулан хариуцсан мэргэжилтнүүдээс тайлан гаргуулж 2013 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж заасан хугацаанд ЗГХЭГ-т хүргүүлсэн. Жилийн эцсийн биелэлтийг гаргаж байна.

“Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2012 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтийн тайланг гаргаж холбогдох газарт хүргүүлээ. Мөн 2013 оны Үндсэн чиглэлийн тус салбарт хамаарах зорилт, арга хэмжээнүүдийн хагас жилийн биелэлтийг гаргасан ба жилийн эцсийн тайлан гаргаж байна.

Хяналт-шинжилгээний газрын дотоод мэдээллийн системийг хөгжүүлэх талаар МУИС-ын МТС-ын оюутнуудтай оны эхэнд хамтран ажиллаж 2 програм хийсэн бөгөөд хэрэглээндээ тохируулан хөгжүүлж ажиллаж байна.

Монгол Улсын Шадар сайдын 2012 оны 42 дугаар тушаалаар батлагдсан “Монгол Улсын хэмжээнд мөрдөгдөж буй үндэсний стандартын шинжлэх ухаан техникийн түвшний улсын үзлэг”-ийг 2013 оны 01-02 дугаар сард мэдээллийн технологи, шуудан харилцаа холбооны салбарт амжилттай зохион байгуулав. Улсын үзлэгийн хүрээнд ХХЗХ болон тус газрын даргын 2013 оны 04/03 дүгээр хамтарсан тушаалаар салбарын төрийн өмчит компаниуд, аж ахуйн нэгж байгууллагууд, их дээд сургууль болон зохицуулах байгууллагын төлөөлөл оролцсон 21 хүнтэй салбар комисс байгуулан ажиллаж 240 гаруй стандартад шинжлэх ухаан, техникийн түвшний үзлэг хийж нэгдсэн тайланг улсын үзлэгийн Төв комисст хүргүүлэв.

Нэгдсэн тайланд стандартын бодлого чиглэлд цаашид анхаарах асуудлууд болон 155 стандартыг дахин хянах, 37 стандартыг хүчингүй болгох, 57 стандарт шинээр боловсруулах санал тусгагдсан нь хэрэгжиж эхлээд байна. Үүнд, Стандартчиллын Үндэсний зөвлөлийн 2013 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 08 дугаар тогтоол гарч тус салбарын 155 стандартыг дахин шинэчлэх, 47 стандартыг хүчингүй болгох шийдвэр гарсан.

Мөн Засгийн газрын 2013 оны 64 дүгээр тогтоол гарсаны дагуу улсын үзлэгийн дүнг үндэслэн Харилцаа холбооны зохицуулах хороо болон тус агентлагийн газар, хэлтсүүдээс санал авч 2013-2014 онд шинээр болон шинэчлэн боловсруулах стандартын жагсаалт гаргаж салбарын стандартчиллын 2013-2014 оны төлөвлөгөөний төсөл боловсруулж СХЗГ-т хүргүүлээ.

Монгол Улсын стандартчиллын 2014-2015 оны төлөвлөгөөний төсөлд санал өгөх ажлын хүрээнд шинээр боловсруулах стандартын санал, өмнөх төлөвлөгөөнд тусгагдаагүй үлдсэн дахин шинэчлэх стандартууд, улсын үзлэгийн тайланд туссан санал зэргийг нэгтгэж ХХЗХ-нд санал хүргүүлэхээр ажиллаж байна.

Мэдээлэл, харилцаа холбооны салбарын 2013 оны хөрөнгө оруулалтын арга хэмжээний хэрэгжилтийн явц байдлын дүнг улирал тутам гаргаж дээд байгууллага, удирдлагуудад мэдээлж ажиллаж байна.

Нийслэлийн мэдээллийн технологийн газартай уулзалт зохион байгуулж цаашид тус газар, нийслэл, ХХЗХ, ҮСХ-ны статистик мэдээллийн солилцоог нэгдсэн маягт аргачлалаар явуулах талаар санал солилцож хамтран ажиллахаар болов.

Газар хэлтсүүд, харьяа байгууллага болон оюутнууд бусад хэрэглэгчдийг 2012 оны захиргааны статистик мэдээллээр хангаж ажиллаж байна. Энэ хүрээндээ статистикийн 2013 оны

эмхтгэл, аж ахуйн нэгж байгууллагын 2011 оны тооллогын тайлан зэрэг мэдээллийг Үндэсний статистикийн хорооноос авч мэдээлэл цуглуулсан.

Засгийн газрын тусгай сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Хөдөө орон нутгийн мэдээлэл, харилцаа холбооны хүртээмжийн судалгаа”-ны техникийн даалгавар боловсруулж БНҮҮС-нд өгсөн. Судалгааны гүйцэтгэгчтэй уулзалт зохион байгуулж, захиалагчийн шаардлагыг танилцуулсан.

Үндэсний статистикийн хорооноос ирүүлсэн хүсэлтийн дагуу НҮБ-ийн Ази, Номхон далайн бүс нутгийн Эдийн засгийн байгууллагад явуулах мэдээллийн технологи, харилцаа холбооны салбарын талаарх статистик мэдээг 2011 оны байдлаар гаргаж тус хороонд хүргүүлсэн.

ЭЗХЯ-ны холбогдох удирдлага, мэргэжилтнүүдтэй ярьж улсын хэмжээнд хийхээр төлөвлөж байгаа хүн амын амьжиргааны түвшний судалгааны асуулгад салбарын зарим үзүүлэлтийг оруулсан.

Сангийн яамны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хяналт-мэдээллийн системд хагас жилийн байдлаар салбарын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний мэдээлэл оруулав.

Төрийн байгууллагуудын нэгдсэн сүлжээний зураглал, нийслэл хотын шилэн кабелийн сүлжээний зураглалыг програмчилсан.

Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газраас үүрэн холбооны оператор компаниудтай нэг минутаас дотогш ярианы төлбөрийг 2013 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн секундээр тооцох тухай шийдвэр гаргасантай холбогдуулан шийдвэрийн хэрэгжилтийн явцын талаарх мэдээллийг оператор компаниудаас албан бичгээр авч удирдлагыг мэдээллээр хангав.

Сангийн яамнаас ирүүлсэн байгууллагын дотоод дахь аудитын тогтолцоо, хэрэгжүүлж буй түвшний талаарх судалгааны асуулгыг бөглөн цахим шуудангаар хүргүүлэв.

Үндэсний Аудитын газрын “Төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн аудит”-ын багийнханд шаардлагатай мэдээллийг нь цаг тухай бүрт нь гаргаж өгч хамтран ажиллав.

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвөөс ирсэн албан бичгийн дагуу салбарын 2010, 2011, 2012 оны зарим нарийвчилсан статистик мэдээг гаргаж odonchimeg@ecrc.mn хаяг руу цахимаар хүргүүлсэн

Тус агентлагаас 2012 оны 12 дугаар сарын 6-ны өдөр Төв аймгийн Зуунмод суманд анхны тоон телевизийн станцыг ажиллуулж, тоон технологийн давуу талыг сурталчлах, одоогийн ашиглаж байгаа аналогич технологийг хэрхэн ялгаатайгаар нэвтрүүлэг хүлээн авч буйг олон нийтэд таниулах өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулсан ажлын хүрээнд урилга, сурталчилгаа мэдээллийн асуудлуудыг хариуцаж амжилттай гүйцэтгэв.

ЗГХЭГ-аас үүрэг болгосны дагуу мэдээллийн сайтуудыг хянах маягыг боловсруулж, тус газрын мэргэжилтнүүдийг хамруулсан хуваарь гарган ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд 04

дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мэдээллийн 60 сайтыг өдөр бүр хянаж илэрсэн зөрчил бүрт холбогдох сайтад шаардлага тавьж сэтгэгдлийн харилцааны журмыг мөрдүүлж ажиллалаа.

Замын цагдаагийн бэлэн бус торгуулийн систем төслийг 2013 оны 11-р сарын 15-нд нээх, үйл ажиллагааг эхлүүлэх зорилгоор төслийн багийнтай 7 хоног тутам уулзаж, саатсан болон шаардлагатай, асуудлаар гүйцэтгэгчийг төрийн байгууллагуудтай шуурхай холбож, шахаж бэлтгэлийг бүрэн хангуулж ажилласан

Тус газрын дэргэд видео сошиал медиа студи байгуулах талаар санаачлан төсөл боловсруулж удирдлагад танилцуулсан нь дэмжигдэж “Ви медиа” студи байгуулагдлаа. Тус студитэй хамтран “IT news” хэвлэлийн 4 дугаарыг гаргаад байна.

Төсөл, хөтөлбөрийн техникийн даалгавар боловсруулах үйл ажиллагаа, хэрэгжилт-хяналтын ажлын албан хэрэгцээ шаардлагын дагуу стандартын улсын үзлэгийн материалд тулгуурлан стандартын 20 гаруй хавтас бүхий архивын нэгж бэлтгэлээ.

Тус агентлагийн газар, хэлтсүүдээс Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний зорилт, арга хэмжээ тус бүрийн тайлан, биелэлтийг хариуцан ажиллах ажилтнуудын нэрсийг гаргуулж АСУ оффис системд оруулж цаашдын үйл ажиллагааг хялбаршуулах алхам хийлээ.

Ажлын хэсгийн ажлын гүйцэтгэл

№	Тушаалын дугаар	Ажлын хэсгийн үүрэг	Ахлагч, н/б дарга	Хугацаа	Ажлын хэсгийн ажлын явц, үр дүн
1.	124/115	Тоон телевизийн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх	Г.Болорчимэг	2013.05.06-2014.07.31	Тус ажлын хэсэг нь Монгол Улсын нийт 371 сум суурин газар тоон телевизийн дахин дамжуулах станцын тоног төхөөрөмжийг суурилуулан байнгын ашиглалтад оруулах ба одоогийн байдлаар нийт 86 сум суурин газар тоног төхөөрөмжүүдийг суурилуулан байнгын ашиглалтад оруулахад бэлэн болоод байна.
2.	31	Тусгай хэрэглээний сүлжээ байгуулах, ашиглахтай холбоотой журам боловсруулах	Н.Баттөр, Г.Болорчимэг	2013.03.30	МУ ЗГХЭГ-ын даргын 2013 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 31 дүгээр тушаалаар “Тусгай хэрэглээний сүлжээ байгуулах, ашиглахтай холбоотой журам боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг” байгуулсан. Тус ажлын хэсгийн нарийн бичгээр ажиллан нийт 9 удаа ажлын хэсгийг хуралдуулан уг журмын төслийг боловсруулсан. Тагнуулын ерөнхий газраас 2013 оны 3 дугаар сарын 29-ний өдөр ЗГХЭГ-т хүргүүлсэн.
3.	ХХЗХ-ны 100	Тоон радиогийн зохицуулалтын чиглэл, техникийн шийдэл боловсруулах	А.Лувсан-Очир н.Тэрбиш	2013.10.01	Тоон радиогийн зохицуулалтын чиглэл, техникийн шийдэл боловсруулан ХХЗХ-ны хурлаар танилцуулан холбогдох байгууллагууд руу тайланг хүргүүлсэн.
4.	186	Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах	Б.Мягмарнар ан Г.Болорчимэг	2013.10.01	Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлал 2011 оны 12 сард ЗГХЭГ болон ХЗДХЯ-р батлагдсан байсан боловч уг хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн үзэл баримтлалыг 2013 оны 7 сард ЗГХЭГ-аас буцаасан. Энэхүү хуулийн төслийг дахин боловсруулах зорилгоор МТШХХГ-ын даргын 2013 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн 186 дугаар тушаалаар “Радио долгионы тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах

					тухай хуулийн төсөл, үзэл баримтлал боловсруулах” ажлын хэсэг байгуулсан. Тус ажлын хэсгийг нийт 5 удаа зохион байгуулж хуулийн төслийг боловсруулсан ба 2014 онд УИХ-д өргөн барих төлөвлөгөөтэй байна.
5.	МТШХХГ	МТХХ-Эспо -2013 зохион байгуулах	Ф.Ганбаа тар Р.Алтангэ рэл	2013.06.15	Үзэсгэлэнг оны 5-р сарын 17-21-ны өдрүүдэд зохион байгуулсан
6.	МТШХХГ 158	Мэдээллийн технологи шуудан харилцаа холбооны салбарын мэдээлэл агуулсан газрын зураг боловсруулах	н/б дарга А.Авадо рж	2013.06.18	Удирдамжийн дагуу ажлын хэсэгт орж ажилласан байгууллагуудын мэдээллийг нэгтгэн цуглуулж, салбарын мэдээлэл агуулсан газрын зураг боловсруулав.
7.	МТШХХГ	Нууцын төслийн үнэлгээ хийх	н/б дарга Ц.Одхүү		Холбогдох журмын дагуу ажиллав.
8.	МТШХХГ 90	Үндсэн сүлжээний зохион байгуулалт, найдвартай ажиллагааны техникийн шийдэл	н/б дарга Ц.Одхүү	2013.03.14	Удирдамжийн дагуу дараагийн ажлын хэсэгт зөвлөмж дүгнэлт хүргүүлсэн.
10.	МТШХХГ 199	Төрийн байгууллагуудыг холбосон мэдээллийн технологийн дэд бүтцийг, байгуулах, цахим засгийг бий болгох үйл явцад чиглэгдсэн стандарт, харилцан уялдаа холбоо бүхий бизнес архитектур, мэдээллийн архитектур, шийдлийн архитектур, технологийн архитектур зэргээс бүрдсэн үр ашигтай системийн шийдлийг боловсруулахад чиглэнэ.	Г. Чинзо риг Б. Эрдэн э	2013-08 2014-06	Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх үндэс суурь болсон архитектурын шийдэл нь бэлэн болсон.

11	МТШХХГ	Монгол Улсын 2014 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтанд санал хүргүүлэх	Б.Мягмарнар ан Р. Алтангэрэл	2013.07	Төсөл боловсруулан ЭЗХЯ, ЗГХЭГ-г хүргүүлсэн.
12	МТШХХГ 229	“Мэдээлэл холбооны үндсэн сүлжээний өргөтгөл, шинэчлэл” төслийн 3-р багцыг байнгын ашиглалтанд оруулах ажлын хэсэг	Ф.Ганбаатар, М.Батхишиг	2013.09.25- 2013.10.20	21 аймгийн 120 сумдад суурилуулсан шилэн кабель, төгсгөлийн тоног төхөөрөмжүүдийг хяналт хийж, зөрчилтэй газруудад үүрэг даалгавар өгч ажилласан. Үүрэг даалгаварын биелэлтийг хүлээн авснаар 72 сумд байнгын ашиглалтанд ороход бэлэн болсон.
13	МТШХХГ 46	Сонгуулийн автоматжуулсан системд ашиглах програм хангамж, техник хэрэгслийн ажиллагааг шалган туршиж баталгаажуулах, гэрчилгээ олгох	Ажлын хэсгийн дарга Ж.Эрдэнэбат Нарийн бичгийн дарга н.Лхамжав Ажлын хэсэгт тус газрын мэргэжилтэн Б.Гарьдмагна й оролцсон	2013.05.27 2013.06.28	Сонгуулийн автоматжуулсан систем, түүний техник хэрэгсэл, програм хангамжийг шалган туршиж, гэрчилгээ олгож амжилтай зохион байгуулсан.
14	МТШХХГ	Нууцын төсөл	Д.Батбаяр Р.Алтангэрэл	2013.12.17	Холбогдох төслүүд
	Төрийн албаны интернэтийн зохистой хэрэглээг бий болгох тухай №5	Төрийн албан хаагчдын албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа компьютерийг интернэтээс тусгаарлах, тухайн компьютерээс мэдээлэл хуулах, мэдээлэл гадагш гаргах аливаа эх үүсвэр, оролтыг хаах, шаардлагатай мэдээллийг зөвхөн албаны электрон		2012.08.25	ЗГХЭГ, МТШХХГ, ТЕГ-ын харъяа КАБГ-тай хамтарсан уулзалтыг зохион байгууллаа. Уг уулзалтаар бүх яамд руу интернэтийн сүлжээг салгаж, интернэтийн орчин бүрдүүлэх тусдаа өрөө тасалгаа, техник хэрэгсэл бэлтгэх, ажлын хэсэг байгуулах, төрийн албан хаагчдын компьютер техник хэрэгсэл, дотоод болон гадаад сүлжээний зохион байгуулалт, электрон шуудан ашиглалтын талаар судалгаа хийх, судалгааны санал асуулга боловсруулах, тогтоол хэрэгжүүлэхтэй холбоотой дүрэм журам боловсруулах, төрийн байгууллагын цахим хуудас, электрон шууданг Үндэсний дата төв рүү шилжүүлэх техникийн боломжийг судлахаар харилцан санал солилцов. МТШХХГ–аас судалгаа авч, журмын төслийг боловсруулан, ЗГХЭГ болон КАБГ-аас ирсэн саналыг тусгаж “Интернэтийн зохистой хэрэглээний журам”-ын төслийг хэлэлцэж батлан, хэрэгжүүлэн

		<p>шуудангийн хаягаар хүлээн авах техникийн боломжийг бүрдүүлж, төрийн байгууллагуудад үүсгэсэн утасгүй интернэтийн бүсийг Төрийн ордноос бусад газарт хааж, тодорхой зөвшөөрөгдсөн газарт ашиглах нөхцөл бүрдүүлэн шаардлагатай дүрэм, журмыг боловсруулж мөрдүүлэхийг Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар, Тагнуулын ерөнхий газарт даалгасугай.</p>			ажиллаж байна.
	<p>Мэдээллийн технологийн чиглэлээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн тухай</p> <p>№67</p>	<p>Төсвийн болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр 2013 онд хэрэгжүүлэх мэдээллийн технологийн төсөл, хөтөлбөрүүдийн уялдаа холбоог хангах талаар төлөвлөгөө боловсруулж, 2012 оны 12 сарын 25-ны өдрийн дотор Засгийн газарт танилцуулахыг Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Жадамбаад</p>		2012.11.17	<p>Засгийн газрын 2012 оны 67-р тэмдэглэлд заасны дагуу Төсвийн болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр 2013 онд хэрэгжүүлэх Мэдээллийн технологийн төсөл хөтөлбөрүүдийн дэлгэрэнгүй танилцуулгыг 2012 оны 11 дүгээр сарын 28-ны 1/257 тоот, 2013 оны 1 дүгээр сарын 28-ны 1/111 тоотой тус тус Төрийн захиргааны 84 байгууллагад хүргүүлсэн.</p> <p>Төрийн захиргааны 57 байгууллага төслийн материалаа ирүүлсэн бөгөөд Төсөл хөтөлбөр байхгүй 18, санхүүжилт нь тодорхойгүй 3, дэмжлэг хүссэн 5, төслийн материал нь хангалтгүй 13, хангалттай 18 материал ирээд байгааг нэгтгэн, боловсруулалт хийж 15 байгууллагад холбогдох төслүүдийг 2014 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөндөө тусгахыг албан тоотой мэдэгдсэн.</p>

	2013.09.27 №234	<p>даалгав.”</p> <p>“Монголын програм хангамж үйлдвэрлэгчдийн анхдугаар форум”-ыг зохион байгуулж, үр дүнг газрын удирдлагад танилцуулахыг ажлын хэсэг /Г.Чинзориг/-т даалгасугай.</p>	Г.Чинзориг Э.Бямбасүрэн	Ажлын хэсэг байгуулах тухай	<p>Монгол Улсын Ерөнхий Сайдын 2013 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн 157 дугаар захирамжаар Жижиг Дунд Үйлдвэрийн хөгжлийн сан, Шинжлэх Ухаан технологийн сан, Сургалтын төрийн сан, Оюуны өмчийн газар, Хөдөлмөрийн Яам, Боловсрол Шинжлэх Ухааны Яам, Арилжааны банкны төлөөллүүд, Уул уурхайн Үндэсний ассоиаци, Монголын програм хангамж үйлдвэрлэгчдийн холбоо, Зээлийн батлан даалтын сан, ЖАЙКА-гийн 2 үе шаттай зээлийн төсөл, Салбарын Их дээд сургуулиуд, Мэдээллийн технологийн консерциум зэрэг байгууллагуудын төлөөлөл орсон ажлын хэсгийг байгуулан програм хангамжийн салбарт тодорхой хөрөнгө оруулалт, санхүүжилтийг бүрдүүлэх, оюуны өмчийн үнэлгээг боловсронгуй болгох, уул уурхайн салбарт мэдээллийн технологи, програм хангамжийн шийдлүүдийг нэвтрүүлэхэд дотоодын програм хангамжийн компаниудыг түлхүү оролцуулахыг бодлогоор дэмжих шийдлүүдийг олж, чуулганы үеэр үр дүнгээ танилцуулах ажлын зохион байгуулсан.</p> <p>Чуулганыг зохион байгуулах ажлын талаар МТ-ийн зөвлөлөөр хэлэлцүүлэн санал авч Ерөнхий сайдад танилцуулан, Ерөнхий Сайдын дэргэд чуулган зохион байгуулах ажлын хэсгийн захирамжийн төслийг боловсруулан ЗГХЭГ-ын Хуулийн хэлтэст хүргүүлсэн.</p> <p>Чуулганыг зохион байгуулахад ивээн тэтгэх 5 байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулсан.</p> <p>Чуулгантай холбоотой мэдээллийг олон нийтэд түгээх үүднээс www.chuulgan.mn домэйн нэр авч, цахим хуудас, фейсбүүк хуудсыг нээсэн.</p> <p>Чуулганд оролцох төрийн захиргааны төв байгууллагууд, Засгийн газрын агентлагууд, Нийслэлийн хэрэгжүүлэгч агентлагууд, Банк санхүүгийн байгууллагууд, МОСА-д бүртгэлтэй салбарын компаниуд, шилдэг аж ахуйн нэгжүүд, салбарын мэргэжилтэн бэлтгэдэг их дээд сургуулиудын төлөөллийн бүртгэлийг хийж, жагсаалтыг гаргасан ба QR кодоороор бүртгэлээ явуулсан.</p> <p>Чуулганы мэдээллийг олон нийтэд таниулах, сурталчилах ажлын хүрээнд Хэвлэлийн хүрээлэнгийн судалгаагаар олон үзэгч, сонсогч, уншигчтай нийт 22 телевиз, 7 цахим хуудас, 6 фм радио, 3 сонин, сэтгүүлтэй хамтран ажилласан.</p> <p>Чуулганы мэдээллийг хийх хэвлэлийн бага хурлыг хэвлэлийн хүрээлэн дээр 2013 оны 10 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулсан.</p>
--	--------------------	--	----------------------------	-----------------------------	--

Хавсралт 2.

Гадаад болон дотоод албан томилолт /албан хаагчдын хамрагдсан Монгол улсад зохион байгуулагдсан сургалтыг мөн энэ хэсэгт бичнэ /

№	Албан хаагчийн нэр	Албан тушаал	Сэдэв	Хаана	Хугацаа	Тайлан өгсөн эсэх /Оролцсон байгууллага/
1	Н.Баатарсүрэн	Ахлах мэргэжилтэн	DWDM, SDH технологи	БНХАУ-ын Шинжин хот	2013.02.27-2013.03.17	
2	Б.Мягмарнаран	Газрын дарга	“Бодлого төлөвлөлт”	Удирдлагын академи	2013.04.15-2013.04.17	
3	В. Батбаяр	Ахлах мэргэжилтэн	Сансрын технологи	БНХАУ Шенжоу инсититут	2013.06.17-2013.07.13	Сансрын зөвлөлийн гишүүн БОНХЯ-ны мэргэжилтэн Б. Отгонтөгсийн хамт оролцсон.
4	В. Батбаяр	Ахлах мэргэжилтэн	Сансрын технологи	Бангладеш АЗНДЦХБ /АРТ/	2013.08.20-2013.08.22	АРТ, HRD төслийн танилцуулга хийгдсэн.
5	Б.Оюунцэцэг	мэргэжилтэн	Тоон өргөн нэвтрүүлгийн хэрэгжилт	Малайз, Кула-лумпур	2013.03.04-2013.03.06	Тайлан өгсөн ОУЦХБ-ын гишүүн улсуудын төлөөлөгчид
6	Б.Оюунцэцэг	мэргэжилтэн	Хиймэл дагуулын хөөргөлт болон зохицуулалтын талаарх Ази, номхон далайн бүсийн семинар	Индонез Ёга-жакарта	2013.06.01-2013.06.06	Тайлан өгсөн ОУЦХБ-ын гишүүн улсуудын төлөөлөгчид
7	Г.Болорчимэг	мэргэжилтэн	Хил орчмын радио давтамжийн зохицуулалтын гэрээний төсөл боловсруулах	О ХУ Москва	2013.04.15-2013.04.19	Тийм

8	Д.Ундармаа Э.Балдансамбуу	мэргэжилтэн	Үйлдвэрийн тест	ХБНГУ Тайснах муж	2013.09.29- 2013.10.04	Тийм
9	Г.Болорчимэг	мэргэжилтэн	"Дэлхийн Радио Холбооны Их Хурал 2015-н бэлтгэл хурал болох APG15-2" хурал	Тайланд Улсын Банконг хот	2013 .07.01- 2013.07.05	Тийм
10	Г.Болорчимэг Д.Ундармаа Э.Балдансамбуу	мэргэжилтэн	Тоон телевизийн дахин дамжуулах станц суурилуулсан сайтуудын тоног төхөөрөмжийг хүлээн авах, байнгын ашиглалтад оруулах улсын комисс	Өмнөговь аймгийн 14 сум, Дундговь аймгийн 15 сум, Говьсүмбэр аймгийн 3 сум, Дорноговь аймгийн 15 сум	2013.05.06- 2013.05.20	Тийм
11	Г.Болорчимэг Э.Балдансамбуу	мэргэжилтэн	Тоон телевизийн дахин дамжуулах станц суурилуулсан сайтуудын тоног төхөөрөмжийг хүлээн авах, байнгын ашиглалтад оруулах улсын комисс	Төв аймгийн 13 сум, Сүхбаатар аймгийн 7 сум, Булган аймгийн 3 сум, Хэнтий аймгийн 3 сум, Дорнод аймгийн 5 сум, Архангай аймгийн 3 сум, Өвөрхангай аймгийн 4 сум	2013.10.21- 2013.11.12	Тийм
	Р.Алтангэрэл	Ахлах мэргэжилтэн	Дараа үеийн хөдөлгөөнт холбоо	АНУ	7	USTTI
	А.Аваадорж	Мэргэжилтэн	Цахим засаглал	Мьянмар	7 хоног	Дэлхийн цахилгаан холбооны байгууллага
	Э.Энхбат	Мэргэжилтэн	Өргөн зурвасын сүлжээний ашиглалт	Япон, Токио	14 2013.12.01- 15	Ази номхон далайн цахилгаан холбооны байгууллага

	Э.Алтанбагана	Мэргэжилтэн	2012 онд хэрэгжүүлсэн төслүүдээс өөрийн хариуцсан төслүүд дээр явцын хяналт болон БАОК байгуулан тухай бүр орон нутагт ажиллав.	Орон нутагт	4-14 хоногийн хугацаатай тухай бүр ажиллаж байсан	Тайлан болон БАОК акт протоколыг боловсруулж батлуулав.
	Э.Алтанбагана	Мэргэжилтэн	Цахим засаг	Солонгос улс	4 сар	Томилолтын тайланг ГХХ-т хүргүүлэв.
	Д.Жавхлан	Мэргэжилтэн	2012 онд хэрэгжүүлсэн төслүүдээс өөрийн хариуцсан төслүүд дээр явцын хяналт болон БАОК байгуулан тухай бүр орон нутагт ажиллав.	Орон нутагт	4-14 хоногийн хугацаатай тухай бүр ажиллаж байсан	Тайлан болон БАОК акт протоколыг боловсруулж батлуулав.
	Д.Жавхлан	Мэргэжилтэн	"Тоон ТВ өргөн нэвтрүүлэг" инеженрийн сургалт	МХС ТӨК-ний сургалтын зааланд	1 өдөр	Холбогдох инженер техникийн ажилтнууд оролцсон бөгөөд мэдээлэл авав.
	Д.Жавхлан	Мэргэжилтэн	Хөдөө орон нутаг дахь мэдээлэл холбооны хөгжлийн өнөөгийн хандлага, бодит байдал түүний хэрэгжилт	Япон улс	11 өдөр	Томилолтын тайланг ГХХ-т хүргүүлэв.
	Б.Гэрэлсүрэн	ХХДТАА-ны мэргэжилтэн	Ази Номхон Далайн Цахилгаан Холбооны байгууллага (АРТ), Малайзын Мультимедиа, Харилцаа холбооны яамтай хамтран зохион байгуулсан Азийн орнуудын Кибер аюулгүй байдлын форум			
	Б.Гэрэлсүрэн	ХХДТАА-ны мэргэжилтэн	НҮБ-ын APCICT-с зохион байгуулсан "Academy of ICT Essentials for Government Leaders" 5дах удаагийн уулзалт			
	Ч.Болор-эрдэнэ	МТИХ-ийн мэргэжилтэн	Ази, Номхон далайн бүс нутгийн хөгжлийн форум, 2014 оны Дэлхийн			

			харилцаа холбооны хөгжлийн бага хурлын Ази, Номхон далайн бүс нутгийн бэлтгэх уулзалт, 2014 оны Дэлхийн харилцаа холбооны хөгжлийн бага хуралд бэлтгэх Ази, Номхон далайн “Цахилгаан холбооны байгууллага”-ын 2 дугаар уулзалт			
--	--	--	--	--	--	--

Зохион байгуулсан сургалт

№	Сургалтын нэр	Хамруулсан иргэд, албан тушаалтан	Хугацаа	Хаана	Хүрсэн үр дүн
1	Олон улсын радио давтамжийн төлөвлөлт	МТШХХГ, ХХЗХ, МХС ТӨК-ний холбогдох албан хаагчид	2013.06.06	Улаанбаатар хот	Хиймэл дагуулын сүлжээний төлөвлөлтүүдэд харгалзан шугамын тооцоолол хийх арга технологид суралцсан
2	Хиймэл дагуулын линкийн тооцоолол” болон “ОУЦХБ-д ашигладаг BRIFIC программ хангамжийн ашиглалт	Сатконсалт компани ХХЗХ, МХС ТӨК-ний инженер техникийн ажилчид	2013.09 сар	Улаанбаатар хот	ОУЦХБ-д ашигладаг BRIFIC програм , хиймэл дагуулын сүлжээ хооронд үүсэж болзошгүй радио давтамжийн нөлөөллийг тооцоолох, түүнээс урьдчилан сэргийлэх, Сансар-1,2,3 хиймэл дагуулын сүлжээний төлөвлөлтүүдэд харгалзан шугамын тооцоолол хийх, API, CR/C хэрхэн боловсруулах асуудал байв.
3	Бага оврын хиймэл дагуул хөгжүүлэлт	APSCO гишүүн орнуудын төлөөлөгчид, Монгол улсын их дээд сургуулиудын багш нар болон оюутнуудын төлөөлөл	2013.09.10-2013.09.04.	Улаанбаатар хот	Бага оврын хиймэл дагуул хөгжүүлэх техник, технологийн ерөнхий мэдлэгтэй болсон.
4	АНДСХАБ-ын Дата хамтран ашиглах системийн сургалт	Сансрын зөвлөлийн гишүүн МУИС-ийн багш Б.Болорчулуун, АМГ-ын мэргэжилтэн М. Мөнгөнтуяа	2013.11.06-2013.11.15	БНХАУ, Бээжин хот	АНДСХАБ-ын Дата хамтран ашиглах системийн сургалт
5	Ургац болон үерийн үеийн ГМС-ийн үнэлгээ	Сансрын зөвлөлийн гишүүн Б.Оюун, Г. Содномрагчаа	2013.10.27-2013.10.31	БНХАУ, Бээжин хот	Ургац болон үерийн үеийн ГМС-ийн үнэлгээ
6	Тоон өргөн нэвтрүүлгийн зохион байгуулсан.	Итали улсын тоон өргөн нэвтрүүлгийн техник технологи, тоног төхөөрөмжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Elettronika	2013.2.20	Пула империа	DVB-T2, DRM стандартууд, тоон телевиз, радиогийн өргөн нэвтрүүлгийн сүлжээний бүтэц, техник, технологийн давуу талууд мөн Монгол улсын тоон өргөн

		Group, Syes, Rai Way, зэрэг компаниуд, Монгол улсын тоон өргөн нэвтрүүлгийн шилжилтийн явцын талаарх мэдээллүүдийг холбогдох байгууллага, компаниудын мэргэжилтэн, инженер техникийн ажилчид			нэвтрүүлгийн шилжилтийн явцыг танилцуулсан.
7	Тоон телевизийн дахин дамжуулах станцын тоног төхөөрөмж дээр практик дадлага олгох сургалт	РТС УТҮГ-ын инженер техникийн ажилчид	2013.09.20	РТС УТҮГ	РТС УТҮГ-ын инженер техникийн ажилчидад тоон телевизийн дахин дамжуулах станцын тоног төхөөрөмж дээр ажиллах практик дадлага олгосон.
8	Rohde & Schwarz үйлдвэр дээр “Үйлдвэрийн тест” хийх	МТШХХГ, ХХЗХ, ДДэш ТВ ХХК, РТС УТҮГ	2013.09.29-2013.10.04	ХБНГУ-ын Тайснах муж & Rohde & Schwarz компани	Rohde & Schwarz компанийн тоног төхөөрөмжийн ажиллах зарчим, аюулгүй байдал, байнгын ашиглалтын талаар ойлголттой болсон.
9	“Тоон телевизийн өргөн нэвтрүүлэг инженерийн сургалт”	МТШХХ, ХХЗХ, РТС УТҮГ, ДДэш ТВ ХХК, телевизийн үйлчилгээ эрхлэгчид, эрдэм шинжилгээний байгууллагууд	2013.10.18	МХС ТӨК хурлын заал	Салбарын инженер техникийн ажилчид тоон телевизийн өргөн нэвтрүүлгийн системийн талаар туршлага судлах, өөр хоорондоо мэдээлэл солилцох боломж бүрдсэн.
10	“Харилцаа холбооны зохицуулалт, хөгжлийн чиг хандлага-2013”	МТШХХГ, ХХЗХ, инженер техникийн ажилчид болон бусад албан хаагчид	2013.11.06-2013.11.07	Өвөрхангай аймаг Арвайхээр сум	Харилцаа холбооны зохицуулалт, хөгжлийн чиг хандлагын талаар мэдээлэл өгөх, тоон систем болон Монгол Улсад хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар ойлголттой болсон.
11	"TOGAF, Энтерпрайз архитектур боловсруулах" сургалт	ЗГХЭГ Яамд, агентлагуудын мэдээллийн технологийн мэргэжилтэнүүд	5 цаг	Рокмон бюлдинг	Төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн мэргэжилтэнүүдэд Энтерпрайз архитектурын тухай мөн TOGAF-ийн зарчмуудийн талаар мэдээлэл

					хүргэсэн.
12	Авлигатай тэмцэх газар	Төрийн байгууллагуудын эрх бүхий албан тушаалтанууд	2013.01.10-2013.01.11	МУИС	“Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн мэдээллийн системийг шалгах, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомж, мэдүүлэг, мэдүүлгийн маягт, тайлан мэдээг хэрхэн гаргах талаар болон мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудыг сургах, мэргэшүүлэх” сургалт
13	Манлайлал ба дагах урлаг	МТШХХГ-ын мэргэжилтнүүд	4 сард	Хурлын заланд	Дагах урлаг гэдэг шинэ ойлголтыг нийтэд түгээв.
14	Албан хэрэг хөтлөлт, баримт бичиг боловсруулалт	МТШХХГ-ын мэргэжилтнүүд	12 сард	Хурлын заланд	Шинэ мэргэжилтнүүдэд зориулан цуврал хичээл заав. Албан хэрэг хөтлөлтийн холбогдох материалуудыг мэйлээр мэргэжилтнүүдэд илгээв.

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ ШУУДАН ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ГАЗАР